

APU COMPANY

Absolute. Pure. Unique.

2021

Ж И Л И Й Н Т А Й Л А Н




**АМЬДРАЛЫН МӨЧ
БҮРИЙГ ХАМТДАА**

БИДНИЙ БҮТЭЭЖ БУЙ ҮНЭ ЦЭН

“ 2021 он цар тахлын сорилт бэрхшээл хэрэглэгч, харилцагчид төдийгүй үйлдвэрлэгчид бидний хувьд хүнд байсан хэдий ч бид тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг эрхэмлэн улс орны нийгэм, эдийн засагт хувь нэмрээ оруулж, урт хугацааны бизнесийн хөгжлийн суурийг бэхжүүлсээр байна.


Бидний зорилго.

Монгол орны органик түүхий эдээр олон улсын түвшний өндөр ур чадвартай мэргэжилтнүүдийн боловсруулсан инноваци шингэсэн технологийн дагуу олон улсад өрсөлдөх брэнд бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд экспортлож дотоодын эдийн засаг, нийгмийн хөгжлийг тогтвортой бодлогын хүчин чармайлтаар түүчээлэхээр зорин эрчимтэй ажиллаж байна.



Нийгэм ба хамтын үнэ цэн.

Нийгэм, хүрээлэн буй орчинд тулгарч буй асуудлуудыг олон талын хамтын хүчин чармайлтаар тодорхойлж, даван туулах арга замуудыг бизнесийн загвар, үйл ажиллагааны зорилтод тусгах замаар тогтвортой хөгжлийн үзэл баримтлалаар нийгмийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулж, итгэлцэл бий болгон хамтын үнэ цэн бүтээж ажиллаж байна.



Эдийн засаг ба хамтын үнэ цэн.

Улс орны хөгжлийн тулах цэг болсон эдийн засгийг дэмжих чиглэлээр экспортын тэлэлтийг онцгой анхаарах, сүү, сүүн бүтээгдэхүүний орлогын төрөлжилтөд анхаарч, түүхий эдийн дахин ашиглалтыг сайжруулах зэрэг замаар ажлын байр бий болгохын зэрэгцээ валютын гарах урсгалыг бууруулж, орох урсгалыг дэмжиж улсын төсөвт бүрдэх татварын орлогыг дэмжиж хамтын үнэ цэн бүтээж байна.

Хэрэглэгч ба хамтын үнэ цэн.

Хариуцлагатай үйлдвэрлэл, бизнесийн экосистемийг бүрдүүлж, хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлага, чанар, стандартад нийцсэн бүтээгдэхүүн нийлүүлэхийн зэрэгцээ нийгэмд чиглэсэн төсөл хөтөлбөрүүд тасралтгүй хэрэгжүүлэх замаар хамтын үнэ цэн бүтээж байна.

Хүн амын дархлаажуулалтын амин чухал хүнс болсон сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээ цар тахлын үед эрчимжүүлж, “Д” амин дэмтэй сүүн бүтээгдэхүүнээ тодорхой хугацаанд ашгийн нэмэгдэлгүй зах зээлд нийлүүллээ.



Харилцагчид ба хамтын үнэ цэн.

Монгол орон даяар 98 жилийн турш хамтран ажилласан 11 мянга гаруй харилцагч, ханган нийлүүлэгч нэгж, байгууллагууддаа зориулж цар тахлын үеийн худалдаа, санхүүжилт, төлбөр тооцооны уян хатан ээлтэй бодлого баримтлахын зэрэгцээ хамтдаа хөгжих, цар тахлын дараах шилжилтийн нөхцөл байдалд дасан зохицох хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүллээ. Үүний зэрэгцээ хэрэглэгчдэд зориулсан идэвхжүүлэлт болон байгаль эх дэлхий, нийгэмдээ ээлтэй, хариуцлагатай, соёлтой орчныг бий болгох төсөл хөтөлбөрүүдээ хамтран хэрэгжүүлсээр байна. Улс орны эдийн засгийн тулах цэг болсон бизнес эрхлэгч, аж ахуй нэгжүүдтэй хамтын үнэ цэн бий болгон ажиллаж байна.

БИДНИЙ БҮТЭЭЖ БУЙ ҮНЭ ЦЭН

7-9

БИДНИЙ ТУХАЙ

- Эрхэм зорилго
- Үзэл баримтлал
- Үнэт зүйлс

11-34

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- ТУЗ-ийн даргын захидал
- Гүйцэтгэх захирлын захидал
- 2021 оны үйл ажиллагааны хураангуй
- 2021 оны зах зээлийн нөхцөл байдал
- 2021 оны экспортын тойм
- 2021 оны санхүүгийн үйл ажиллагааны ерөнхий тойм
- Гүйцэтгэх удирдлагын баг
- АПУ Групп компанийн бүтэц
- Хүн төвтэй засаглалын бодлого
- Бидний туулсан замнал
- Үйлдвэрлэл, үйл ажиллагааны ололт амжилтууд
- Байгууллагын хөгжил
- Бүтээгдэхүүн хөгжүүлэлт
- Эрсдэлийн удирдлага

35-40

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

- Компанийн ерөнхий мэдээлэл
- Компанийн засаглалын өөрийн үнэлгээ
- Хувьцаа эзэмшигчид
- Төлөөлөн удирдах зөвлөл
- Хувьцааны мэдээлэл
- Ногдол ашгийн мэдээлэл

41-54

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН

- АПУ ХК-ийн тогтвортой хөгжлийн тэргүүлэх зорилт
- Бидний 2021 оны зорилт
- Ковид 19 цар тахлын үеийн нийгэмд чиглэсэн бодлого
- Аюулгүй байдал ба эрүүл мэнд
- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах
- Хуурай газрын экосистемийг хамгаалах
- Чанартай боловсролыг дэмжих
- Хариуцлагатай хэрэглээг дэмжих

55-

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

- Дэлгэрэнгүй орлогын тайлан
- Санхүү байдлын тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан
- Өмчийн өөрчлөлтийн тайлан
- Тайлагналын зарчим
- Тайлбар толь

АГУУЛГА

01



БИДНИЙ ТУХАЙ

- Эрхэм зорилго
- Үзэл баримтлал
- Үнэт зүйлс



ҮЗЭЛ БАРИМТЛАЛ



Бид бүхий л түвшинд чанарыг эрхэмлэж, хэрэглэгч, харилцагч, хамтрагчдынхаа эрхэм сонголт байна.



Бид хүн, нийгэм ба эх дэлхийд ээлтэй үйл ажиллагаа явуулж, байгальд сөргөөр нөлөөлөх нөлөөллийг алхам бүртээ багасгаж, гэрэлт ирээдүйг хамтдаа цогцлооно.



Бид баяр хөөртэй, дахин давтагдашгүй, нандин сайхан мөчүүдийг түгээнэ.



АМЖИЛТ ӨӨД ХАМТДАА

- Бид хамтын ажиллагаа, хамтын шийдвэр гаргалт, хүн бүрийн оролцоог бүрдүүлж, нээлттэй харилцааг эрхэмлэдэг.
- Харилцан итгэлцэл, хүндлэл, эерэг дулаан харьцааг бий болгон үр дүнтэй хамтран ажилладаг.
- "Би" бус "Бид" зарчмыг дээдэлдэг.
- Бид аливаад хамтдаа ялахын төлөө ажилладаг ба win-win зарчмыг дээдэлдэг.



БУСДЫГ ДЭЭДЛЭН ЭРХЭМЛЭ

- Хүнсний болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг эн тэргүүнд ханган ажилладаг.
- Бид байгаль орчиндоо ээлтэй үйл ажиллагаа явуулж, эх дэлхийгээ хайрлан дээдэлдэг.
- Бид нийгэмдээ үйлчилж, нийгмийн хөгжил дэвшилд өөрийн үнэтэй хувь нэмрийг оруулдаг.
- Бид хууль дүрмээ чандлан сахиж, шударга ёсыг эрхэмлэн ажилладаг.



СУРАЛЦ. НЭЭ. ХӨГЖ.

- Бид мэдлэг, ур чадварыг эрхэмлэн дээдэлдэг. Өөрийгөө болон бусдыг хөгжүүлэх нь ажилтан бүрийн эрхэм үүрэг.
- Хэрэглэгч, харилцагч, зах зээлийн талаарх мэдлэг, судалгаа, шинжилгээнд үндэслэн аливаа шийдвэрийг гаргадаг.
- Бид үргэлж шинийг судалж, эрэлхийлж, шинэ зах зээл, шинэ хил хязгаарыг нээхийг эрмэлздэг.



УЛАМЖЛАЛАА ХҮНДЭЛ, ШИНИЙГ БҮТЭЭ

- Бид үргэлж уламжлалаа дээдэлж, шинийг эрэлхийлж, шинэ шийдэл, шинэ бүтээгдэхүүн, шинэ үнэ цэнийг бүтээдэг.
- Ажилтан бүр нээлттэй санал санаачилга гаргаж, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэн ажилладаг.
- Бид бусдаас түрүүлж, бусдаас түргэн хөдөлдөг.



ҮЛГЭРЛЭН МАНЛАЙЛ

- Бид хааш тэмүүлж, юунд зорьж буйгаа мэддэг.
- Бид салбар, зах зээл бүртээ манлайлахын төлөө ажилладаг.
- Аливаад эзний ёсоор хандаж, бусдыгаа уриалан дууддаг.
- Хүн бүр манлайлагч байхыг хүсдэг, бас чаддагт итгэдэг.
- Хүн бүр бусдыг үлгэрлэн манлайлж, нөлөөлж нийгмийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэдэг.



02



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- ТУЗ-ийн даргын захидал
- Гүйцэтгэх захирлын захидал
- 2021 оны үйл ажиллагааны хураангуй
- 2021 оны зах зээлийн нөхцөл байдал
- 2021 оны экспортын тойм
- 2021 оны санхүүгийн үйл ажиллагааны ерөнхий тойм
- Гүйцэтгэх удирдлагын баг
- АПУ Групп компанийн бүтэц
- Хүн төвтэй засаглалын бодлого
- Бидний туулсан замнал
- Үйлдвэрлэл, үйл ажиллагааны ололт амжилтууд
- Байгууллагын хөгжил
- Бүтээгдэхүүн хөгжүүлэлт
- Эрсдэлийн удирдлага



Пүрэв
БАТСАЙХАН

“Энэ бол “Цар тахлын дараах шинэ эгэл” үеийн эхлэл бөгөөд бид саад тотгор, хямрал бэрхшээл бүрийг боломж хэмээн харж, эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэн, АПУ ХК-ийн харилцагч, хэрэглэгчдийнхээ эрх ашгийг дээдлэн, итгэл даан ажиллах болно.

ЭРХЭМ ХҮНДЭТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ЭЭ,
АПУ Компанийн хамт олны нэрийн өмнөөс та бүхэнд 2021 онд гаргасан ахиц дэвшил, амжилт бүтээлийн талаар тайлагнан мэндчилж байна.

Өнгөрсөн 2021 он бидний түүхэнд тодоор бичигдэн үлдэх жилүүдийн нэг байж, харилцагч, хэрэглэгч, хувьцаа эзэмшигч та бүхний дэмжлэгтэйгээр КОВИД-19 цар тахлын сөрөг нөлөөг даван туулж, Монгол Улсын хөрөнгийн зах зээл дээрх 1 их наяд төгрөгийн үнэлгээтэй анхны компани болсон билээ.

Энэ амжилтын шийдвэрлэх хүчин зүйл нь АПУ Компанийн чадварлаг ажилтан албан хаагчид, нэгэн зорилгын төлөө хүч нэгтгэн ажиллаж буй удирдлагын багийн хүчин чармайлт, сэтгэл зүтгэл байсныг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

2021 оны санхүү, үйл ажиллагааны үр дүнг харгалзан Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан хоёр удаагийн шийдвэрээр нэгж хувьцаанд нийт 106 төгрөгийн ногдол ашиг хуваарилснаар АПУ Компани Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудыг дахин манлайллаа.

2021 оны 11-р сард Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Өлзийдэлгэрийн Батбаяр Монгол Улсаас АНУ-д суух Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайдаар томилогдсонтой холбоотойгоор түүнийг нөхөн сонгууль хүртэл орлохоор Одончимэдийн Одбаяр томилогдон ажиллаж байна. Ө.Батбаяр нь 2017 оноос хойш Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллахдаа олон улсын харилцаа, бизнес хөгжлийн өргөн мэдлэг туршлагаа хуваалцан, компанийн үйл хэрэгт үнэтэй хувь нэмэр оруулсныг энэ ялдамд онцлон тэмдэглэж, АПУ Компанийн хамт олон болон Төлөөлөн удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлж байна.

Аливаа хувьцаат компанийн хувьд үйл ажиллагааны амжилт, хөрөнгө оруулагчдын итгэл хүлээх чадварыг илтгэх үзүүлэлт нь хувьцааны ханш, хувьцаа эзэмшигчдийн тоо билээ. Өнгөрсөн түүхээ эргэн харвал, шингэн хүнсний зах зээл дээрх хамгийн том компаниудын нэгдэн нийлэх ажиллагаа явагдсан 2017 оны эцсээр бид 5 мянга хүрэхгүй хувьцаа эзэмшигчтэй, хувьцааны ханш 700 орчим төгрөг байжээ. 2021 оныг бид 12 мянга гаруй хувьцаа эзэмшигчтэй, хувьцааны үнэ 1800 төгрөг давсан үзүүлэлтэйгээр үдсэн байна. АПУ Компани Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудаас анхлан 1 их наяд төгрөгийн үнэлгээнд хүрсэн амжилтаа ахиулан, 1 тэрбум ам.долларын үнэлгээтэй компани болох цаг мөч ойртон ирж буй гэдэгт би итгэж байна.

2022 он гарснаас хойш бид геополитикийн амаргүй нөхцөл байдал, үйлдвэрлэлийн түүхий эд материалын хомсдол, үнийн өсөлт, тээвэрлэлтийн саад бэрхшээл зэрэг цөөнгүй хүндрэл бэрхшээлтэй учирч байна. Энэ бол “цар тахлын дараах шинэ эгэл” үеийн эхлэл бөгөөд бид саад тотгор, хямрал бэрхшээл бүрийг боломж хэмээн харж, эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэн, АПУ Компанийн харилцагч, хэрэглэгчдийнхээ эрх ашгийг дээдлэн, итгэл даан ажиллах болно.

Пүрэвийн

Батсайхан



Цэвээнжав
ЭРДЭНЭБИЛЭГ

“Компанийн хэмжээнд экспортын орлогыг нэмэгдүүлэх зорилгыг тэргүүлэх чиглэл болгосноор хоёр том стратегийн зах зээлд онцгой өсөлт бий болголоо.

Эрхэм хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, хамтран ажилладаг түнш байгууллагууд, хүндэт хэрэглэгч та бүхний амгаланг эрэн мэндчилье.

Дэлхий даяар тулгарсан цар тахлын сорилт, бэрхшээл хоёр дахь жилдээ дамнасан 2021 онд бид шинэ нөхцөл байдалд дасан зохицож, хөгжлийн дараагийн үе шатны суурийг бэлтгэн ажиллалаа.

2021 он бидний хувьд 98 жилийн түүхтэй үндэсний компанийн хувиар дэлхийд өрсөлдөх их зорилгын хурдасгуур болсон жил байлаа. Компанийн хэмжээнд экспортын орлогыг нэмэгдүүлэх зорилгыг тэргүүлэх чиглэл болгосноор хоёр том стратегийн зах зээлд онцгой өсөлт бий болголоо. Тухайлбал ОХУ-д хийсэн экспортын хэмжээ 220 гаруй хувиар, БНХАУ-д хийсэн экспортын хэмжээ 440 гаруй хувиар тус тус өслөө.

Эдийн засгийн нөхцөл байдал сорилт дүүрэн байсан ч орлогын төрөлжилтөд анхаарч сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлийн боломжийг тэлэх, үйлдвэрлэл, үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах суурь судалгаа, стратегид онцгой анхаарахын зэрэгцээ зардал хэмнэлтийн хувьд бодит хүчин чармайлт гаргасан нь санхүүгийн үзүүлэлтэд эергээр нөлөөллөө.

Энэ ч утгаараа Монголын хөрөнгийн бирж дээрх зах зээлийн үнэлгээг хөрөнгө оруулагчид үнэлэн ₮1 их наяд хол давсан амжилттай жил болсон нь бидний хувьд цаашид дэлхийд тавьсан зорилгоо биелүүлэх хөрөнгө оруулагчдын итгэлцэл бэхжиж буйн илрэл гэж үзэж байна.

Мөн компанийн хэмжээнд “Agile” менежментийн тогтолцоог нэвтрүүлж өндөр гүйцэтгэлтэй компани, хэрэглэгч, харилцагчидтайгаа бий болгох хамтын үнэ цэн, хамтын амжилтыг бэхжүүлэх тэргүүтэй 6 чиглэлд анхааран ажилласан нь байгууллагын соёл, засаглалын оновчлол, шийдвэр гаргалтын хурд сайжрах нөхцөл болохын зэрэгцээ зах зээлийн шинэ нөхцөл байдалд дасан зохицох урт хугацааны хөгжлийн чиг баримжаагаа удирдлага болгон хэрэгжүүлэхэд дэвшил боллоо.

Нийгэмд чиглэсэн “Тогтвортой хөгжлийн” үзэл баримтлалын дагуу хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдээ эрчимжүүлсэн нь цаашид хүн, нийгэм, эх дэлхийдээ ээлтэй, хариуцлагатай хэрэглээг тасралтгүй бий болгоно гэж итгэж байна.

АПУ ХК нь нийт хамтрагч, харилцагч, хэрэглэгч, ажиллагсадтайгаа үнэт зүйлсээрээ холбогдож хамтын үнэ цэн бүтээж, дэлхийд өрсөлдөх нэг зорилгын төлөө нэгдэн ажиллаж байна.


Бидэнтэй хамт 98 жилийн түүхийг бүтээж, хөгжиж, дэвшиж буй нийт хамтрагч, харилцагч, хэрэглэгч та бүхэндээ баярлалаа.

Цэвээнжавын

ЭРДЭНЭБИЛЭГ


Цэвэр борлуулалтын орлого
тэрбум төгрөг

38%




Борлуулалтын тоо хэмжээ
сая.литр

22%



Цэвэр ашиг
тэрбум төгрөг

73%



Татвар төлөлт
тэрбум төгрөг


38%



Бүтээгдэхүүний төрөл
SKU



Ажилчдын тоо



Монголын анхны ₮1 их
наядаар хэмжигдэх үнэлгээтэй
хувьцаат компани болов.



₮1 ИХ НАЯД



АРХИН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ

2021 онд Монгол улсын архин бүтээгдэхүүний зах зээл биет хэмжээгээр 29 сая литр хүрсэн байна. АПУ ХК нь 2021 оны байдлаар нийт 15 брэндийн бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд үйлдвэрлэн нийлүүлж байна.



СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ

2021 онд Монгол улсын сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээл



Сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээл өсөлттэй байгаа нь цар тахлын үед хэрэглэгчид эрүүл мэнддээ чухал ач холбогдол өгч байгаатай холбоотой юм. Нийт зах зээлийн 50 гаруй хувийг сүүн бүтээгдэхүүн эзэлж байгаа бол үлдсэн 50 гаруй хувийг бусад сүүн бүтээгдэхүүнүүд эзэлж байна. АПУ Дэйри ХХК нь хүн амын дархлаажуулалтын амин хүнс болсон "Д" амин дэмээр баяжуулсан сүү үйлдвэрлэж буй цорын ганц дотоодын үйлдвэрлэгч билээ.



ДАРСНЫ ЗАХ ЗЭЭЛ

2021 онд Монгол улсын дарсны зах зээл



“АПУ” ХК нь дэлхийд алдартай Франц улсын “Maison Castel”, “Albert Bichot”, Испани улсын “Faustino”, Чили улсын “Vino Maipo” болон Итали улсын “Ruffino” брэндүүдийг Монголын хэрэглэгчдэд хүргэж байна



УС, УНДАА, ШҮҮСНИЙ ЗАХ ЗЭЭЛ

2021 онд Монгол улсын хийжүүлсэн ундааны зах зээл биет хэмжээгээр



Савласан жимсний шүүсний зах зээл



Савласан жимсний шүүсний зах зээл



АПУ ХК нь 2021 оны байдлаар эдгээр зах зээлд онцгой анхаарч уламжлал, шинэчлэл хосолсон шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд манлайлан ажиллаж байна.



ШАР АЙРГИЙН ЗАХ ЗЭЭЛ

2021 онд Монгол улсын шар айргийн зах зээл



АПУ ХК нь 2021 онд нийт 9 брэнд бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд нийлүүлсэн бөгөөд 0.0 агууламжтай шар айргийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд нэвтрүүлж хариуцлагатай, зөв зохистой хэрэглээний соёлыг түгээж ажиллаж байна.




ИМПОРТЫН ВИСКИ БОЛОН БУСАД ЗАХ ЗЭЭЛ

2021 онд Монгол улсын импортоор орж ирж байгаа виски болон бусад бор спиртэн бүтээгдэхүүний нийт зах зээл



АПУ ХК нь 2021 оны байдлаар нийт 10 гаруй улсын 12 брэндийн 25 нэр төрлийн бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлж байна.






2021 ОНЫ ЭКСПОРТЫН БОРЛУУЛАЛТЫН ӨСӨЛТ:

ОХУ:  **+220%**

БНХАУ:  **+440%**



"Shanghai Cooperation Organization International Trade Expo", Чиндао хот

2021 оны 5-р сар



АПУ ХК ОХУ-ын Татспиртпром компанитай стратегийн уулзалт зохион байгуулав.

2021 оны 10-р сар



ОХУ-ын Үндэсний "Дегустатор" шалгаруулах тэмцээнтэй хамтран ажиллалаа.

2021 оны 11-р сар

2021 оны 4-р сар

"The China International Consumer Products Expo 2021", Хайнань муж



2021 оны 5-р сар

"China Food & Drinks Fair", Тяньжин хот



2021 оны 11-р сар

"China International Import Expo", Шанхай хот



“ БНХАУ-ын зах зээлд тусгайлан зориулан Сэнгүр брэндийн 4 нэр төрлийн бүтээгдэхүүний хөгжүүлэлт хийв. Уг төсөл 3 сарын хугацаанд АПУ ХК-ийн инженерүүдийн тусламжтайгаар амжилттай хэрэгжиж, дараах 4 төрлийг зах зээлд нэвтрүүлээ:

- a. Сэнгүр
- b. Сэнгүр white
- c. Сэнгүр Радлер Лемон
- d. Сэнгүр Радлер Манго

“ БНХАУ-ын Өвөрмонголын Долоон нуурт анх удаа зохион байгуулагдсан хамгийн том залуучуудын хөгжмийн фестивалд Сэнгүр брэнд онцгой эрхтэйгээр оролцож, эцсийн хэрэглэгчдэд сурталчлан таниулан борлуулалтыг өмнөх оны мөн сартай харьцуулахад 411% өсгөв. Уг хөгжмийн фестивалд давхардсан тоогоор 300,000 үзэгчид оролцсон бөгөөд нийт 7 хоног үргэлжилсэн юм.

“ Цар тахал болон тээвэр ложистикийн хүндрэл бэрхшээлтэй энэ үед Бүгд Найрамдах Солонгос улсын нийлүүлэлтийг тасралтгүй хангахын тулд агаарын тээврээр бүтээгдэхүүнээ амжилттай нийлүүлэв.



“ ОХУ-ын №1 "ГУМ" их дэлгүүрт АПУ ХК-ийн "Chinggis khan" брэнд худалдаалагдаж эхэллээ.




		Аудитлагдсан НСТ	Аудитлагдсан НСТ	Өсөлт %
		2021	2020	
БОРЛУУЛАЛТЫН ТОО ХЭМЖЭЭ	мян. литр	170,210	139,650	21.9%
ОРЛОГО ҮР ДҮН				
Цэвэр борлуулалтын орлого	сая.төг	678,164	492,337	37.7%
Үйл ажиллагааны ашиг	сая.төг	197,893	115,840	70.8%
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	153,686	88,743	73.2%
БАЛАНС				
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	251,637	204,585	23.0%
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	365,575	351,078	4.1%
Нийт хөрөнгө	сая.төг	617,212	555,663	11.1%
Нийт өр төлбөр	сая.төг	112,226	94,048	19.3%
Нийт эздийн өмч	сая.төг	504,987	461,616	9.4%
Нийт эздийн өмч ба өр төлбөр	сая.төг	617,212	555,663	11.1%
МӨНГӨН ГҮЙЛГЭЭ				
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	181,647	144,433	25.8%
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(65,594)	(36,114)	81.6%
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(102,770)	(94,925)	8.3%
Бусад мөнгөн гүйлгээ	сая.төг	(65)	631	-110.3%
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	13,218	14,024	-5.7%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	сая.төг	64,059	50,035	28.0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	сая.төг	77,278	64,059	20.6%
ТАТВАР ТӨЛӨЛТ				
Онцгой албан татвар	сая.төг	211,313	166,882	26.6%
Нэмэгдсэн өртгийн албан татвар	сая.төг	69,359	48,065	44.3%
Бусад	сая.төг	84,338	49,967	68.8%
Нийт татвар төлөлт	сая.төг	365,010	264,914	37.8%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ				
Нийт хөрөнгө оруулалт	сая.төг	69,151	46,808	47.7%



Цэвээнжавын
ЭРДЭНЭБИЛЭГ
Гүйцэтгэх захирал



Добрев
НИКОЛАЙ
Үйлдвэрлэл, үйл ажиллагаа
эрхэлсэн захирал



Батсайханы
ЦАЦРАЛ
Борлуулалт эрхэлсэн захирал



Дандарова
АРИУНА
Маркетинг эрхэлсэн захирал,
Бус нутгийн экспорт эрхэлсэн
захирал



Жаргалсайханы
ИЧИНХОРЛОО
Захиргаа, Хүний нөөц
эрхэлсэн захирал



Гончигийн
ЭНХБИЛЭГ
Санхүү эрхэлсэн захирал



Галсумъяагийн
БАЯРМАГНАЙ
АПУ Дэйри ХХК-ийн Гүйцэтгэх
захирал,
АПУ ХК-ийн Байгууллагын
харилцаа эрхэлсэн захирал



Цоодолын
ЭРДЭНЭЖАРГАЛ
Бус нутгийн экспорт эрхэлсэн
захирал



Батхүрэлийн
ЧИНТОГТОХ
СББ ХХК-ийн Үйл Ажиллагаа
Хариуцсан Захирал



Батсайханы
ГАНТИГ
Стратеги эрхэлсэн захирал



Пүрэвжавын
ЦЭНД-АЮУШ
Тээвэр, Түгээлт эрхэлсэн
захирал



Эрдэнэбилэгийн
ОТГОНБИЛЭГ
Монголын зах зээл
дэх брэнд хариуцсан
маркетингийн албаны дарга

APU COMPANY

Absolute. Pure. Unique.



APU TRADING
Absolute. Pure. Unique.

CHINGGIS KHAN INTERNATIONAL LIMITED

APU DAIRY
Absolute. Pure. Unique.



MBC ASIA PACIFIC



Хараат компани



Бүтцэд гарсан өөрчлөлт:

АПУ ХК нь Дижитал Концепт ХХК-ийн 39%-ийн хувьцаа эзэмшигчээр 2021 оны 01 сарын 20-ны өдөр бүртгүүлсэн. Дижитал Концепт ХХК нь Шунхлай групп ХХК, АПУ ХК, БНСУ-ын хуулийн этгээд болох Жи Эс Рэтайл Ко. Лтд-ийн хамтарсан хөрөнгө оруулалттай компани бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт "GS25" 24 цагийн конвениенс дэлгүүрийн франчайзын эрхийг эзэмшдэг.

Нийт ажилтан



Нийт эрэгтэй ажилтан



Нийт эмэгтэй ажилтан



Ковид-19 цар тахлын үеийн ажилтны эрүүл мэндийг дэмжих бодлого:

Дархлаа дэмжих багц - Эрүүл мэндийн багцыг бүх ажилтнуудад олгов.



Зайнаас ажиллах боломж бүхий ажлын байрны уян хатан зохицуулалт хийв



Ковид-19 цар тахалтай холбоотойгоор гарч буй эдийн засгийн ачааллыг хөнгөвчилж ажилтан бүрт **₮1 сая** мөнгөн урамшуулал олгов.



2021 онд цалингийн дундаж өсөлт **14%** байв

Бүх ажилтнуудаа Ковид-19 цар тахлын үеийн эрүүл мэндийн эрсдэлийн даатгалд хамруулж эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо хийлгэв.



АПУ ХК-ийн Агуулах, тээвэр, түгээлтийн албаны агуулахын ахлах менежер **Ш.Энхсайхан**:

“ Ажил үүргийнхээ онцлогоос шалтгаалан цаг агаарын ямар ч нөхцөл, гэнэтийн үйл явдал, өдөр шөнийн алинд ч бэлэн байдаг шижигнэсэн залуусын маань нуруун дээр манай алба тогтдог. Багийн ажиллагаа гэдэг бидний хувьд хамгийн чухал учраас нэг хүн мэт нэгдэн, хамтын хүчийг нийлүүлэн нэгэн зүгт залахыг гол болгон ажилладаг. Байгууллагын хүссэн үр дүнд хүргэх процессыг хөдөлгөгч хүч нь хүн учраас хамтран ажилладаг ажилтан бүрийн итгэл хүндлэлийг хүлээсэн хамтрагч байхыг би хувьдаа хичээдэг.



Монгол Улсын Аж үйлдвэрийн гавьяат ажилтан, Хүнсний салбарын зөвлөх инженер, Спирт бал бурам ХХК-ийн мэргэжлийн зөвлөх **З.Чантуу**:

“ Анх Москвагийн оюутан байхдаа АПУ ХК-д ирж ажиллана гэсэн яриа маань олон жилийн дараа М-Би-Си болон АПУ ХК компаниуд маань нэгдэхэд сая нэг биелсэн дээ. Миний хувьд шингэн хүнсний салбарт ажиллаад 40 гаруй жил болсон байна. Гэсэн ч өөрийгөө бүгдийг чаддаг мэддэг гэхгүй ахиад ч шинээр суралцах, цаг үеэсээ хоцрохгүйн тулд хичээх зүйлс гарч ирсээр байдаг. Үүнийг ч компанийн зүгээс маш сайн дэмжиж, жил бүр биднээс ямар ур чадварыг сайжруулах, ямар сургалтад хамрагдах хүсэлтэй байгааг лавлаж тэр чиглэлд бэлтгэдэг. Монголд ийм компани хэр их байдгийг би мэдэхгүй байна. Тийм ч олон биш болов уу.



Шар айргийн үйлдвэрийн ахлах технологич **П. Аззаяа**:

“ Ажил мэргэжлийн хувьд би ирээдүйд хийсэн зүйлээ эргүүлээд харж, барьж, мэдэрч болдог тийм л зүйлийг хүсэж байлаа. Энэ хоёр хүсэл, зорилго маань нэгдэж, би Германы Hochschule Geisenheim University-д Шингэн хүнсний технологич мэргэжлээр суралцсан. Өмнө нь ажиллаж байсан Германы Дармштадт хотын шар айргийн үйлдвэр хагас автомат байсан болохоор олон зүйлийг заавал гараар хийх хэрэг гардаг байсан. Пивоны исгэлтийн танкийг л гэхэд дандаа дотор нь орж зүлгэж, шүршиж угаадаг гэх мэт. Харин АПУ-д ирээд тоног төхөөрөмжийн хувьд илүү хөгжсөн, автомат үйлдвэр байсан нь ажиллахад урамтай байсан. Гадаадад мэргэжил эзэмших нь давуу тал байдаг ч миний хувьд АПУ-д ажилд орсноосоо хойш түүнээсээ ч илүү их зүйлийг сурч мэдсэн.





АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

- 2021 онд аюулгүй ажиллагааны өндөр гүйцэтгэлтэй ажиллаж 100 ажилтан тутамд ногдох ослын давтамжийг 59% бууруулав.
- “Аюулгүй ажиллаад аз жаргалтай харьцгаая”, “Аюулгүй ажиллагааны манлайлагч” аян зохион байгуулав.



ҮЙЛДВЭР ТӨЛӨВЛӨЛТ

Цар тахлын үеийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны уян хатан, эрсдэл тооцсон хөрвөх чадвартай төлөвлөлтөд анхаарч ажиллав.



ЧАНАРЫН УДИРДЛАГА

Олон улсын Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандартыг дэлхийд тэргүүлэгч SGS компанийн аудитад зайнаас шалгуулан, баталгаажууллаа
“Quality is everything” Чанарын долоо хоногийг 11-р сард амжилттай зохион байгууллаа.

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Шинэ нөхцөл байдалд уян хатан жор орц, технологийн оновчлолыг бий болгож бүтээгдэхүүний тасралтгүй нийлүүлэлтэд анхаарч ажиллав.
“Brewhouse” төсөл, шар айргын үйлдвэрийн зарим өргөтгөл, нэмэлт жор орцын хөгжүүлэлт, ус, эрчим хүчний хэмнэлт, импортыг орлох сэлбэг материалын инноваци, шалгах процессийн автоматжуулалт, ус хүлээн авах хяналтын системийн сайжруулалт зэргийн тусламжтай үйл ажиллагааны зардлын хэмнэлтэд онцгой анхаарав.



ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

- Импортыг орлох тоник, сода ус, шүлтлэг ус тэргүүтэй шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж валютыг гарах урсгалыг бууруулахад хувь нэмэр оруулав.
- Цар тахлын үед бага хэмтэй, хатуулаг багатай, эмийн ургамал агуулсан зөөлөн бүтээгдэхүүний хөгжүүлэлтэд анхаарч “Алтангагнуур 17%”, “Тайга Алтангагнуур 33%”, “Тайга Хунчир 33%” хандмал бүтээгдэхүүнүүд, “Eve Grapefruit”, “Eve coffee 17%” бүтээгдэхүүн нэвтрүүлэв.
- 0 градустай, хатуулаггүй шар айрагны сонголтыг бий болгож, хариуцлагатай хэрэглээний соёлыг бий болгох зорилгоор Heineken 0.0% шар айраг нэвтрүүлэв.



- Уламжлалаа дээдлэх үнэт зүйлсээ эрхэмлэн Arkhi брэндийн 45 жилийн ойд зориулсан онцгой бүтээгдэхүүнийг нэвтрүүлэв.

БҮТЭЭМЖИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМ

- МВС АР Үйлдвэр “TPM Maturity” аудитад амжилттай орж Bronze үйлдвэрлэлийн шаардлагыг ханган Ази бүсийн 10 дахь үйлдвэр болж чадлаа.
- АПУ ХК-ийн шар айраг үйлдвэрлэлийн хэсгүүд TPM буюу Бүтээмжийн удирдлагын системийн хэрэгжилтийн үйл явцаа шалгуулсан анхны “TPM Maturity” аудитад амжилттай орлоо.
- Аюулгүй ажиллагаа болон Процесс үйл ажиллагаанд гарч байгаа асуудал доголдуудыг бүртгэх системийг автоматжуулах TPM deviation төсөл амжилттай хэрэгжиж эхэллээ.



ХУДАЛДАН АВАЛТ

Бүх төрлийн бараа ажил үйлчилгээний үнэ өсч, импортын зарим туслах түүхий эдийн тасалдал үүссэн нөхцөл байдалд тасралтгүй зардал хэмнэх бодлого баримтлан эхний гурван улиралд нэг тэрбум гаруй төгрөгийн хэмнэлт хийв.



ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ

Үйлдвэрлэл үйл ажиллагааны “Дижитал болон технологи” стратегийн хүрээнд 2021 онд Ultimate ERP, Power BI, Qulass болон Process Automation хэсэгт төвлөрч ажиллалаа. Бараа материалаас эхлэн, харилцагчийн гарт хүлээлгэн өгөх бүх алхмыг цахим бүртгэлжүүлж, алхам тутмыг хянах боломжтой болгосон Ultimate ERP программыг хэсэгчилсэн байдлаар интеграцлаж нэвтрүүлэв.
WIP төслийн хүрээнд Inventory module-ийн эхний үе шатанд зарим бүтээгдэхүүний захиалгыг автоматжуулахын зэрэгцээ дараагийн шатны үйлдвэрлэлийн процессийн бүртгэлийн автоматжуулалтын төслийг үе шаттай хэрэгжүүлж ажиллаж байна.





АПУ Академи

- АПУ Академийн 2025 он хүртэлх стратеги, бодлогын баримт бичгийг боловсруулав.
- SME trainer буюу анхны АПУ Академийн 10 сургагч багш бэлтгэгдэв. Уг багш нар нь олон улсын Master trainer хөтөлбөрийн дагуу бэлтгэгдсэн анхны багш нар гэдгээрээ онцлог юм.
- АПУ Академийн сургагч багш нарын сайн дурын клуб буюу APU Academy Community and trainers' hub үндэслэн санаачлав.
- АПУ Санхүүгийн Академийг албан ёсоор нээн ажиллаж байгууллагын тасралтгүй хөгжлийг бэхжүүлсээр байна.

Mentorship хөтөлбөр

Менторшип 2021 хөтөлбөрийн анхны 22 төгсөгчдийг өлгийдөн авлаа. Менторшип хөтөлбөр нь залуу ажилтнуудад карьер төлөвлөлт, хувь хүний хөгжил болоод мэргэжлийн зөвлөгөө, коучинг үйлчилгээг ажлын байрнаасаа авах боломжийг бүрдүүлж буйгаараа онцлог юм. Менторшип 2022 буюу 2 дах удаагийн элсэлтийг 20 ментеетэйгээр эхлүүлж залгамж халааг бүрдүүлэн ажиллаж байна. 2022 оны хувьд байгууллагад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж буй нь үйлдэнгээ суралцах боломж бүрдүүлж буйн илрэл билээ.



Монгол улсдаа анхлан **Great Place to Work** буюу "Ажиллахад таатай газар" олон улсын гэрчилгээг хүлээн авлаа.

Судалгааны үр дүн: **84%**



Байгууллагын DNA соёлын судалгаа

PWC (USA) байгууллагын албан ёсны эрхтэй судалгаагаар АПУ ХК нь 81% үнэлгээтэйгээр "Өндөр гүйцэтгэл бүхий байгууллагын соёлтой" байгууллага хэмээн баталгаажсан нь олон улсын түвшинд үнэлэгдэж буйн томоохон илрэл боллоо.

Онлайн сургалт

- Ковидын үед тасралтгүй суралцах боломжоор хангах зорилгоор 1300 гаруй ажилчдыг 15 төрлийн хувь хүний хөгжлийн цахим сургалтад хамрууллаа.
- World class manager буюу Harvard-ын албаны ёсны эрхтэй сургалтад 120 ажилтан хамруулав.
- LinkedIn онлайн сургалтын эрх олгох зэргээр онцгой анхаарч ажиллалаа.

Байгууллагын үнэт зүйлст тулгуурласан үндсэн, суурь ур чадвар олгох ажлыг эрчимжүүлэв.

АПУ ХК-ийн эрхэм зорилго, шинэчлэгдсэн үнэт зүйлст суурилсан үндсэн ур чадварыг ажиллагсдадаа үе шаттайгаар олгоход онцгой анхаарч, байгууллагын зорилго, хувь хүний зорилгыг нэгтгэх замаар бүтээмж, гүйцэтгэлийг шинэ түвшинд гаргахаар хүний нөөцийн цогц бодлого хэрэгжүүлж байна.

Хүний нөөцийн "Green ERP" систем

Хүний нөөцийн хөдөлмөрийн харилцаа, цаг бүртгэл, цалин, гүйцэтгэлийн удирдлагын платформийг нийт групп компанийн түвшинд амжилттай нэвтрүүллээ.


Хүний нөөцийн автоматжуулалтын систем нь цаасан харилцааг хөнгөвчилж, вэбсайт, гар утасны аппликейшн, Киоск буюу өөртөө үйлчлэх системийг цогцоор нь хөгжүүлсэн томоохон ахиц дэвшил боллоо.

Дижитал HR

Хүний нөөцийн Green ERP систем, APU Communication app, Power BI зэрэг дотоод цахим системүүдийг интеграци хийсэн нь бүтээмжийг дээшлүүлэх суурь нөхцлийг бүрдүүллээ.


Коучинг соёл

Дэлхийд алдартай PWC Академитай хамтран 16 коуч нарыг бэлтгэн гаргалаа. Уг бэлтгэгдсэн коуч нар нь нийт 200 ажилтанд сурсан мэдсэнээ түгээж, коучинг соёл бүрдүүлж байгууллагын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж байна.



БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

Шинээр болон шинэчлэн зах зээлд гаргасан брэндүүд



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА


Цар тахлын шинэ хувилбар, тархалтын тоо эрчимжиж, геополитикийн хурцадмал байдал үргэлжлэхийн хэрээр гадаадын болон дотоодын зах зээлд хүндхэн сорилт учирч, урьдчилан тооцоолох боломжгүй тодорхойгүй нөхцөл байдал үүсч байгаа билээ. 2021 онд цар тахлын хариу арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж дэлхийн эдийн засгийн прогноз, тооцоолол эерэг болсон хэдий ч ОХУ-Украйн, АНУ-БНХАУ зэрэг дэлхийн эдийн засгийн томоохон тоглогч нарын харилцаа хурцадмал байдал руу шилжсэн нь бизнесийн орчин эргэн сэргэх, хумигдсан эдийн засаг тэлэх таатай орчныг сааруулж байна.

Манай компанийн хувьд ч мөн адил уг бэрхшээлийг даван туулах үүднээс санхүүгийн оновчтой удирдлага хэрэгжүүлж, бизнесийн тасалдалгүй үйл ажиллагааг ханган, үр ашиггүй

зардлыг бууруулахад чиглэн ажиллаж байна. Үүнд: тэвчиж болох зардлыг танаж, тэргүүлэх чиглэлд тодорхой компани ажил зохион байгуулан, өндөр өгөөж бүхий төсөл хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлж, хүндээ чиглэсэн ээлтэй бодлогыг баримтлан ажиллаж байна.

2021 онд АПУ групп компанийн хэмжээнд эрсдэлийн удирдлагын програмын тусламжтайгаар эрсдэлийн нарийвчилсан анализ үнэлгээ хийж, бууруулах төлөвлөгөөг боловсруулан, мөшгөлт хийж, удирдлагыг шаардлагатай мэдээллээр ханган ажиллахын зэрэгцээ, эрсдэлийн соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор тодорхой төсөл хөтөлбөр, хамтын ажиллагаануудыг санаачлан хэрэгжүүлж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд дэмжин ажилласан.

ЭРСДЭЛИЙН ЗУРАГЛАЛ



ТОП ЭРСДЭЛҮҮД

ЮУ ТОХИОЛДОЖ БОЛОХ ВЭ?

Дэлхийн эдийн засгийн өсөлт 2020 онд цар тахлын нөлөөллөөр зогсонги байдалд орсон боловч 2021 оны эхнээс вакцинжуулалтын үйл явц эрчимжиж эдийн засгийн өсөлтийн эерэг төсөөлөл бий болсон. Харин 2021 оны сүүлээс эхлэн цар тахлын шинэ хувилбар БНХАУ, БНСУ тэргүүтэй олон улсад идэвхтэй тархсан нь Монгол улсын экспортын түвшин буурч, эдийн засаг хумигдах, цаашлаад гадаад шууд хөрөнгө оруулалт, бизнесийн эргэлт удааших эрсдэлийг үүсгэж байна.

КОВИД-19 ЦАР ТАХАЛ

Ковид-19 компанийн үйл ажиллагаанд учруулж буй нөлөөлөл:

- Хилээр хугацаандаа нэвтэрч чадаагүй бараануудын тээвэрлэлт, хадгалалтын зардал өссөнөөс шалтгаалан үйлдвэрлэлийн зардал огцом өсөх
- Цар тахлын нөлөөлөл жижиг, дунд бизнес эрхлэгчдэд илүү хүнд туссангай холбоотойгоор харилцагч нарын авлагын хэмжээ ихсэх
- Халдварын тархалт өсч, нэг хүнд ногдох ажлын ачаалал нэмэгдэх

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛӨЛ

Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд дотоодын эдийн засгийн идэвхжилд дэмжлэг үзүүлж байгаа хэдий ч геополитикийн тогтворгүй байдлаас шалтгаалсан олон улсын төлбөр тооцооны свифт гүйлгээний саатал, валютын нөөц, түүхий эд, бараа бүтээгдэхүүний хомсдол, экспорт гарцын хумигдал зэрэг нь бизнесийн салбарын өсөлтийг сааруулж байна. Түүнчлэн дайнаас үүдэлтэй цахилгаан эрчим хүч, нефть, улаанбуудайн үнийн өөрчлөлт нь инфляцын түвшинд ихээхэн нөлөөлөл үзүүлж байна. Цаашид хөрш орнуудын нөхцөл байдалтай холбоотойгоор бизнесийн тодорхой бус байдал үргэлжлэхээр байна.

САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД НӨЛӨӨЛӨХҮЙЦ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Салбарын үйл ажиллагаанд нөлөөлөхүйц хуулийн төсөл хэлэлцэгдэж байгаа нь компанийн үйлдвэрлэл, борлуулалт мөн түүнчлэн импорт, экспортод тодорхой хэмжээний хязгаарлалтыг үүсгэх эрсдэлтэй байна.

ХИЛ ГААЛИЙН ХЯЗГААРЛАЛТ, ТЭЭВЭР ЛОЖИСТИК

Олон улсын үйлдвэрлэл, хангамжийн гинжин хэлхээний систем нь коронавирус, геополитикийн тогтворгүй байдлын нөлөөллөөр тасалдан түүхий эдийн татан авалтын хугацаа удааширч байгаа.

- Үйлдвэрлэлийн голлох түүхий эд болох улаан буудай, сахар, лааз, шил зэргийн нөөцийн төлөвлөлтийг нарийн тооцож, төлөвлөх хэрэгцээ шаардлага тулгарсан.
- Хилийн боомтуудын ачаалал нэмэгдсэн, Хятад улс тодорхойгүй хугацаагаар гол боомтуудаа хаасан, ОХУ-Украины дайн зэрэг шалтгааны улмаас ложистик тээвэрлэлтийн хомсдол үүссэн нь үйлдвэрлэл үйл ажиллагаанд томоохон сорилт учруулж байна.

ХЭРЭГЛЭГЧИЙН БОДИТ ОРЛОГО БУУРАХ, ХЭРЭГЛЭЭНИЙ ШИЛЖИЛТ

Монгол улсын хэмжээнд медиан цалингийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад нэмэгдсэн хэдий ч инфляцын өсөлт бодит орлогын хэмжээг бууруулахад хүргэлээ. Мөн цар тахлын нөлөөгөөр хүн амын эдийн засгийн идэвх суларч ажилгүйдлийн түвшин нэмэгдэн орлогогүй иргэдийн тоо өссөнөөр хүмүүсийн худалдан авах чадварт нөлөөлж хэрэглээний шилжилтийг үүсгэж байна. Статистик үзүүлэлтээс харахад хүнсний голлох бүтээгдэхүүний зарцуулалт өнгөрсөн оноос өссөн дүнтэй байгаа ба ялангуяа манай компанийн үйл ажиллагаа болон борлуулалттай хамааралтай эм эмнэлгийн хэрэгсэл (гар ариутгагч), сүүн сүүн бүтээгдэхүүн худалдан авалтын өсөлт нь өөдрөг төсөөллийг авч ирж байна.

ЭРСДЭЛИЙГ УДИРДАХЫН ТУЛД БИД ЮУ ХИЙЖ БАЙНА ВЭ?

- Халдвар тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор түргэвчилсэн тестийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эмч эмнэлгийн ажилтны орон тоог нэмэх, өвчлөлөөс хамгаалах бүхий л арга замуудыг таниулах
- Мэргэжлийн компаниар дамжуулан оффис болон үйлдвэрийн ариутгал, цэвэрлэгээг тогтмол хийх
- 70:30, 50:50 уян хатан хэлбэрээр ажиллаж халдварын эрсдэлийг бууруулах
- Шаардлагагүй зардлыг тэвчиж, хүндээ чиглэсэн үйл ажиллагаанд хөрөнгө оруулах, зээл болон авлагын бодлогод анхаарах

АПУ ХК нь тэвчиж болох зардлыг хэмнэх, үнэ цэнэ өгөх капиталд хөрөнгө оруулах мөн бизнесийн тасалдалгүй үйл ажиллагааны төлөвлөгөө, хямралын үеийн менежмент, урт хугацааны мөнгөн хөрөнгийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх замаар тулгарч буй хүнд нөхцөл байдлыг даван туулж байна.

Компанийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, бусад байгууллагуудтай хамтран зохистой хэрэглээг сурталчилсан ажлуудад, идэвхтэй оролцох, зохион байгуулах

- Түүхий эдийн нөөцийн төлөвлөлтийг оновчтой тооцоолох, ТЭМ бэлтгэн нийлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх чиглэлд гэрээ хэлэлцээр хийх
- "Шилээ дахин амьдрулъя төсөл"-ийг амжилттай хэрэгжүүлж, алдагдсан боломжийн зардлыг бууруулах, байгаль, нийгэмд ээлтэй төсөл хөтөлбөрүүдийг дэмжин ажиллах

- Зах зээлийн судалгаа, статистик мэдээлэл дээр үндэслэн хэрэглээний шилжилтэд тохирсон оновчтой арга хэмжээ авах, хэрэглээний зөв соёлыг таниулах

ОЭЗ



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

- Компанийн ерөнхий мэдээлэл
- Компанийн засаглалын өөрийн үнэлгээ
- Хувьцаа эзэмшигчид
- Төлөөлөн удирдах зөвлөл
- Хувьцааны мэдээлэл
- Ногдол ашгийн мэдээлэл

Оноосон нэр:
АПУ

Хэлбэр:
Нээлттэй хувьцаат компани

Регистрийн дугаар:
2702673

Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:
Монголын хөрөнгийн бирж

МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал:
I

Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг:
1,064,181,553

Бизнесийн үндсэн үйл ажиллагааны салбар:


- **Архины үйлдвэрлэл**
- **Шар айрагны үйлдвэрлэл**
- **Спиртийн үйлдвэрлэл**
- **Ундаа, ус, жүүсний үйлдвэрлэл**
- **Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл**

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг тодорхойлох үнэлгээний үр дүн

Тэмдэглэгээ	Үндсэн зарчмууд	Асуултын тоо	Зорилтот үр дүн		Бодит үр дүн	
			Оноо	Хувь	Оноо	Хувь
А	Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчдийн хурал	20	40	20%	33	16.5%
Б	Хувьцаа эзэмшигчдийн ижил тэгш байдал	10	20	10%	16	8.0%
В	Оролцогч талууд	10	20	10%	14	7.0%
Г	Ил тод нээлттэй байдал	20	40	20%	35	17.5%
Д	Төлөөлөн удирдах зөвлөл	30	60	30%	42	21.0%
Е	Гүйцэтгэх удирдлага	10	20	10%	13	6.5%
НИЙТ		100	200	100%	153	77%

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН БҮТЭЦ¹




ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН ХУРАЛ

Компанийн эрх барих дээд удирдлага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм.

АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04-р сарын 23-ны өдөр цахимаар болж, дараах шийдвэрүүдийг гаргав. Үүнд:

1. АПУ ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан "АПУ групп компани 2020 онд тавьсан зорилтуудаа бүрэн биелүүлж, амжилттай ажилласан" гэсэн дүгнэлтийг батлав.
2. АПУ ХК-ийн Дүрмийн 7-р зүйлийн 7.2 дахь хэсэгт "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг эрх бүхий байгууллагын баталсан журмын дагуу 7.2.1. танхимаар буюу хувьцаа эзэмшигчдийг биечлэн оролцуулах замаар; 7.2.2. мэдээллийн технологийн шийдэл ашиглан зайнаас буюу цахим хэлбэрээр; 7.2.3. танхимаар ба зайнаас хосолсон байдлаар зохион байгуулж болно." гэсэн нэмэлт өөрчлөлтийг оруулж, батлав.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН ТОО²



¹ ҮЦТХТ ХХК-аас гаргасан 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх үнэт цаасны төвлөрлийн судалгааны мэдээлэл

² Дээрхийн адил

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) компанийг удирддаг.

ТУЗ-ийн дараах бүрэлдэхүүн Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн дотоод дүрэм журамд заасан АПУ ХК-ийн ТУЗ-ийн болон түүний охин, хараат компаниудын хувьцаа эзэмшигчдийн

хурлын бүрэн эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлж ажиллав.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн хараат бус гишүүн Өлзийдэлгэрийн Батбаяр чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тул ТУЗ-ийн хурлаар 2021 оны 11 сарын 01-ний өдөр үүрэгт ажлаас чөлөөлж, Одончимэдийн Одбаярыг нөхөн сонгууль хүртэл түр томилсон.



ПҮРЭВИЙН БАТСАЙХАН
ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга

Шунхлай групп ХХК-ийн Ерөнхийлөгч



БҮРЭНТОГТОХЫН БАТБАЯР
ТУЗ-ийн ердийн гишүүн

Шунхлай групп ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал



СЕРГЕЙ ГРОМОВ
ТУЗ-ийн ердийн гишүүн

Монгол Даатгал ХК-ийн ТУЗ-ийн дарга



КЕННЕТ ЧУ
ТУЗ-ийн ердийн гишүүн

Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийг хариуцсан Гүйцэтгэх захирал



СЭН И-ИН
ТУЗ-ийн ердийн гишүүн

Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийн Хууль эрхзүй хариуцсан захирал



ТОМАС ХОЛЛАНД
ТУЗ-ийн ердийн гишүүн

Девелопмент Финанс Азия компанийн Хөрөнгө оруулалт хариуцсан захирал, Гүйцэтгэх захирал



Одончимэдийн ОДБАЯР
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ард даатгал ХК, Ард холдинг ХХК, Монгол шуудан ХК-уудын ТУЗ-ийн гишүүн



ЁНДОН-ОЙДОВЫН ГЭРЭЛЧУЛУУН
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Нээлттэй хот ТББ-ын үүсгэн байгуулагч



ЖИГЖИДИЙН ҮНЭНБАТ
ТУЗ-ийн хараат бус гишүүн



ЧАДРААБАЛЫН АРИУНСАН
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

ТУЗ-ийн бүрэлдэхүүний 56%-ийг Монгол, 44%-ийг гадаад гишүүд эзэлж байна.



ТУЗ-ИЙН ХУРЛЫН СТАТИСТИК

Огноо	Ирц	Баталсан тогтоолын тоо
2021 оны 02 сарын 15	100%	2
2021 оны 03 сарын 10	100%	7
2021 оны 06 сарын 08	89%	5
2021 оны 08 сарын 16	100%	2
2021 оны 10 сарын 06	100%	3
2021 оны 10 сарын 22	100%	6
2021 оны 11 сарын 01	100%	1
2021 оны 12 сарын 06	100%	12
2021 оны 12 сарын 21	100%	2
Нийт	99%	40

ТУЗ-ИЙН ЦАЛИН УРАМШУУЛАЛ

ТУЗ-ийн дарга болон гишүүдэд сар бүр тогтмол цалин олгодог бөгөөд үйл ажиллагааны гүйцэтгэлтэй уялдсан урамшууллын тогтолцоо байхгүй.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

ТУЗ-ийн хороод	Аудитын хороо	Нэр дэвшүүлэх хороо	Цалин урамшууллын хороо
Бүрэлдэхүүн	Ж.Үнэнбат (Хорооны дарга) Сэн И-Ин Ө.Батбаяр (О.Одбаяр)	П.Батсайхан (Хорооны дарга) Ө.Батбаяр (О.Одбаяр) Ё.Гэрэлчулуун	Ё.Гэрэлчулуун (Хорооны дарга) Ж.Үнэнбат Кеннет Чу
Компанийн дүрэмд заасан чиг үүрэг	<ul style="list-style-type: none"> Санхүүгийн тайлан санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавих, Нягтлан бодох бүртгэлийн бодлогод хяналт тавих, зөвлөх, Хяналтын болон эрсдэлийн удирдлагын бодлогод хяналт тавих, зөвлөх, Компанийн дотоод аудитын нэгжийн удирдлага, ажилтныг томилж санал боловсруулах, тэдгээрийн цалин урамшууллын хэмжээг тогтоох санал боловсруулах, Аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал өгөх, Их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах, ТУЗ-өөс даалгасны дагуу тодорхой асуудлаар хяналт шалгалт хийх, дүгнэлт гаргах 	<ul style="list-style-type: none"> ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох; ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүний хувьд Компанийн тухай хуулийн 79.1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх; ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх; ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх; Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах; ТУЗ-ийн гишүүнээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах 	<ul style="list-style-type: none"> Компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих; ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах; Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

АПУ ХК-ийн гаргасан нийт хувьцаа	1,064,181,553
Халаасны хувьцаа	1,206,810
Эргэлтэд буй хувьцаа	1,062,974,743

АПУ ХК-ийн зах зээлийн үнэлгээ 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 1.9 их наяд төгрөгт хүрч, зах зээлийн үнэлгээгээр тэргүүлэгч компанийн байр сууриа хэвээр хадгаллаа. АПУ ХК нь МХБ-ийн зах зээлийн үнэлгээний 32%-ийг дангаар бүрдүүлж байна.

Тайлант хугацаанд хувьцааны арилжааны үнийн дүнгийн эрэмбээр 4-т, тоо хэмжээний эрэмбээр 10-т тус тус жагссан байна.

Хувьцааны хаалтын ханш:

- дунджаар 1,023.42 төг,
- хамгийн ихдээ 1,804 төг,
- хамгийн багадаа 586.55 төг байв.



НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ


Ногдол ашгийн төлбөрийг нийт хувьцааны таваас доош хувийг эзэмшигчдэд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар зуучлуулан, таваас дээш хувийг эзэмшигчдэд компаниас шууд төлөх замаар мөнгөн хэлбэрээр олгож байна.

Ногдол ашгийн хуваарилалт (сүүлийн 5 жил)

Тайлант хугацаа	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төг)	ТУЗ-өөс ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн өдөр	Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр
2017 он	10	2018 оны 02 сарын 19	2018 оны 03 сарын 29
2018 он	46	2019 оны 02 сарын 19	2019 оны 04 сарын 04
2019 он	71	2020 оны 02 сарын 14	2020 оны 03 сарын 23
2020 он	95		
Үүнээс: I хагас жил	37.5	2020 оны 08 сарын 13	2020 оны 09 сарын 02
II хагас жил	57.5	2021 оны 02 сарын 15	2021 оны 03 сарын 31
2021 он	106		
Үүнээс: I хагас жил	46	2021 оны 08 сарын 16	2021 оны 09 сарын 03
II хагас жил	60	2021 оны 02 сарын 17	2021 оны 04 сарын 08

Ногдол ашиг хуваарилалт (2017–2021)

Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төг)



04



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН

- АПУ ХК-ийн тогтвортой хөгжлийн тэргүүлэх зорилт
- Бидний 2021 оны зорилт
- Ковид 19 цар тахлын үеийн нийгэмд чиглэсэн бодлого
- Аюулгүй байдал ба эрүүл мэнд
- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах
- Хуурай газрын экосистемийг хамгаалах
- Чанартай боловсролыг дэмжих
- Хариуцлагатай хэрэглээг дэмжих



Бид 2021 онд НҮБ-аас баталсан дэлхийн улс орнууд бүх нийтээр дэмжин хүн бүрт хөгжил цэцэглэлтийг хүртээмжтэй байлгах, ядуурлыг бууруулах, эх дэлхийгээ хамгаалахыг зорьж буй тогтвортой Хөгжлийн 17 зорилтыг хэрэгжүүлэх хүчин чармайлтаа эрчимтэй нэмэгдүүлэн ажиллаж байна.

Бидний зорилго бол эх дэлхийдээ үзүүлэх аливаа сөрөг нөлөөллүүдийг хязгаарлаж, нийгэм, эдийн засагт оруулах эерэг хувь нэмрийг улам нэмэгдүүлэх явдал юм.

АПУ ХК-ийн ажиллагсад, харилцагчид, хамтран ажилладаг түнш байгууллагууд, ханган нийлүүлэгчид, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд зэрэг тал бүрийн хамтын хичээл зүтгэл нь урт хугацаанд үргэлжлэх бодит үр дүнд хүрэх зам юм.

Бидний төвлөрөх зургаан чиглэл нь Тогтвортой Хөгжлийн Зорилтуудтай уялдах тул бид ил тод байдал, хамтын зөвшилцөл, хамтын шийдлийг чухалчлах болно. 2021 онд бид тэргүүлэх чиглэл, стратегийнхээ дараагийн үешатыг тодорхойлохоор ажиллаж байна.

МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ

“Тогтвортой хөгжил -2030 хөтөлбөр”-ийг анх 2012 онд Рио Де Жанейро хотод улс орнуудын төрийн тэргүүнүүд оролцсон НҮБ-ын “Тогтвортой хөгжил” бага хурлын үеэр санаачилсан. Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ) нь 2015 онд хэрэгжилтийн хугацаа нь дуусгавар болж буй “Мянганы хөгжлийн зорилтууд”-ын үргэлжлэл юм. 2015 онд НҮБ-ын Ерөнхий Асамблейн 70 дугаар чуулган болж, ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилтыг баталж, 2016 оны 1 сарын 1-нээс “Тогтвортой хөгжлийн зорилго” (ТХЗ) албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн.

Ковид 19 цар тахлын үеийн нийгэмд чиглэсэн бодлого

Ковид 19 цар тахлын үед хэрэглэгч, харилцагч, олон нийтэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдээ эрчимжүүлэв

Цар тахлын нөхцөл байдлаас хамааран өдрийн орлого нь тасалдсан зорилтот бүлгийн айл өрхүүдэд тусламж дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ харилцагч, хэрэглэгчдэд чиглэсэн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүдэд онцгой анхаарал хандуулж ажиллалаа.

Ковид 19 цар тахлын үеийн “Аюулгүй байдал” ба “Эрүүл мэнд”

Цар тахлын үеийн ажилтнууддаа чиглэсэн эрүүл мэнд, аюулгүй байдлын бодлого

Цар тахлын үеийн бодлогод онцгой анхаарал хандуулж ажилтнууддаа шуурхай вакцинд хамруулж, аюулгүй байдлыг ханган, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн ажиллалаа.

Уур амьсгалын өөрчлөлтийг нөлөөг бууруулах

Дотоод ажилтнууддаа зориулсан “Мод бид хоёр” төсөл

Уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн ихээр нөлөөлж буй цөлжилт, хуурайшилтын эсрэг компанийн дотоод ажиллагсдын хувийн ногоон байгууламжид хөрөнгө оруулж мод, зүлгээр хангахын зэрэгцээ тогтмол арчлан ургуулах сургалт мэдээллээр хангав. Мөн үйлдвэрлэлийн түвшинд ус, эрчим хүч, дулаан алдагдлыг бууруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх бүх талыг хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Хуурай газрын эко системийг хамгаалах

Экологийн Цагдаагийн албатай хамтарсан “Байгаль Эн Тэргүүнд” төсөл

Тогтвортой хөгжлийн зорилго болох Хуурай газрын эко системийг хамгаалах, тэр дундаа биологийн олон янз байдлыг хангахын тулд ховордсон ан амьтныг хамгаалах чиглэлээр “Байгаль эн тэргүүнд” төслийг Экологийн Цагдаагийн албатай хамтран амжилттай хэрэгжүүлэв.

Чанартай боловсролыг дэмжих

Нийгмийн эерэг өөрчлөлтөд манлайлагч оюутан залуусыг дэмжих “Маргаашийн Манлайлагчид” төсөл

“Тогтвортой Хөгжил”-ийн үндсэн суурь зарчимд (Зорилго 4. Хүртээмжтэй, тэгш чанартай боловсролоор хангах, хүн бүрийн насан туршдаа суралцах боломжийг дэмжин хөхүүлэх) түлхэц өгөх зорилгоор 100 оюутанд тэтгэлэг өгөхөөр зарлав. Тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд эхний шатанд 1500 гаруй оюутан материал ирүүлсэн бөгөөд 100 оюутан шалгаруулж сар тутмын мөнгөн тэтгэлэг, сургалт, хөгжлийн хөтөлбөр, байгаль эх дэлхийдээ ээлтэй, нийгмийн эерэг өөрчлөлтийн төлөөх шийдлээ хүлээж буй олон асуудлуудад гарц гаргалгаа гарган хамтран ажиллалаа.

Хариуцлагатай хэрэглээг дэмжих

Хүн, байгаль, хүрээлэн буй орчиндоо ээлтэй соёлыг түгээх “Соёлоор Гоёно” төсөл

Урлаг, соёл, бизнес, хүний эрхийн салбарын олон талт хамтын оролцоотойгоор бидний нийгэмд шаардлагатай соёлыг тодорхойлж, ухамсар сэтгэлгээ, хандлага өөрчлөх, хариуцлагатай, үнэт зүйлтэй амьдралын хэв маягийг сурталчлан таниулах нөлөөллийн ажлыг шат дараатайгаар зохион байгуулж ажиллалаа.

Ковид 19 цар тахлын үеийн нийгэмд чиглэсэн ээлтэй бодлого

Бидний зорилт:

Ковид 19 цар тахлын үед хэрэглэгч, харилцагч, олон нийтэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдээ эрчимжүүлэв

“Дэм дэмэндээ-2” аянд нэгдэн өдрийн орлого тасалдсан иргэдэд тусламж үзүүлэв.

Коронавируст цар тахлын нөлөөллийн улмаас ажлын байр нь түр хаагдсан, орлого нь тасалдсан айл өрхүүдэд тусламж үзүүлэх зорилгоор “Дэм дэмэндээ-2” аян нийслэлийн хэмжээнд өрнүүлсэн. Энэхүү аяны эхлэл болж АПУ ХК 500 багц хүнсний тусламжийг үзүүлж Сонгинохайрхан дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгч хүнс, ахуйн хэрэглээний тусламжийн багцыг дүүргийн 43 хорооны 500 өрхөд хүлээлгэн өглөө.



Дархлаажуулалтын амин хүнс “Д” витаминтай сүүг ашгийн нэмэгдэлгүй хүргэв.



Судалгаагаар монголчуудын 90 гаруй хувьд нь Д амин дэмийн дутагдалтай гэж гарсан байдаг. Тиймээс цар тахлын үетэй холбогдуулж “АПУ Дэйри” компани худалдан авагчдынхаа дархлааг дэмжихээр “Д” витаминаар баялаг “САЙН” сүүгээ үйлдвэрийн өртгөөр хүнсний дэлгүүрүүдэд 2 сарын турш худалдаалсан юм.

Харилцагчдын мэдлэг, боловсролд хийх хөрөнгө оруулалт

Монгол улсын шингэн хүнсний салбарт тэргүүлэгч, экспортын чиг баримжаатай үйлдвэрлэл эрхлэгч АПУ ХК нь Монгол орны өнцөг булан бүрт буй бизнес эрхлэгч, **10 мянга гаруй** харилцагчдынхаа мэдлэг оюунд хөрөнгө оруулалт хийж, салбарын хөгжилд бодитоор хувь нэмэр оруулах зорилгоор “Амжилтын төлөө Хамтдаа 2021” цахим хэлэлцүүлэг зохион байгуулж олон нийтэд хүргэв.



Уг хэлэлцүүлгээр цар тахлын хүнд үед сорилт, бэрхшээлийг хэрхэн даван туулах талаар худалдаа үйлчилгээ эрхлэгчид, бизнесийн салбарынхан, сэтгэл зүйч, брэнд бүтээгчдийн

төлөөлөл оролцож бодитоор нүүр тулсан хүндрэлүүдийг хэрхэн боломж болгон хувиргах талаар зөвлөгөө, мэдээлэл өгч нийт **800 гаруй мянган** хүнд хүрлээ.

ТХЗ-д оруулж буй хувь нэмэр:



Ковид 19 цар тахлын үеийн “Аюулгүй байдал” ба “Эрүүл мэнд”

Бидний зорилт:

Цар тахлын үеийн ажилтнууддаа чиглэсэн эрүүл мэнд, аюулгүй байдлын бодлогод анхаарах

Бидний үйлдвэрлэл, үйл ажиллагаандаа баримтлах зарчим бол “Аюулгүй байдал үргэлж нэгт” юм.

Аюулгүй байдлын манлайлал

2021 онд АПУ компани “Аюулгүй ажиллагааны манлайлагч” аяныг 2 дахь жилдээ зохион байгуулж байна. Аюулгүй ажиллагааны санал санаачилга гарган, эерэг зөв хандлагаар аюулгүй ажиллах технологийг өөртөө болон бусдад зуршил болгоход чиглэсэн, тасралтгүй 3 сар үргэлжлэх аянд хамрагдаж Борлуулалтын газрын 127 ажилтан (худалдааны төлөөлөгч, мерчиндайзер, аудитор) болон Агуулах, тээвэр түгээлтийн албаны 134 жолооч амжилттай оролцлоо.

Ослын давтамж

Манай ослын давтамж 2021 оны эхний хагас жилийн байдлаар 100 хүн тутамд 0.0 үзүүлэлттэй байна. Энэ нь 2020 онтой харьцуулахад 100%-иар буурсан (100 FTE тутамд 0.19) бөгөөд бид 2021 оны зорилтоо биелүүлсэн гэсэн үг юм.



Хөдөлмөрийн чадвар алдалт үүссэн осол бүртгэгдээгүй, ажлын байран дээр анхны тусламж аваад ажлаа үргэлжлүүлсэн жижиг бэртлийн тохиолдол 7 бүртгэгдсэн байна.

2021 оны эхний хагас жилд ослын тохиолдлууд буурсан нь COVID-19 цар тахлын үеийн хөл хорио, хязгаарлалттай холбоотой. Хөл хорио болон хязгаарлалтын хугацаанд ажилтнуудыг аль болох зайнаас ажиллуулах бодлого баримтлан гэрээсээ ажиллах нөхцөл бололцоогоор хангасан.

Бидний эрсдэлд суурилсан аюулгүй байдлын стратеги

2021 онд бид аюулгүй байдлын шинэ стратегиа эхлүүлсэн. Шинэ стратеги нь бидний хамгийн өндөр эрсдэлд төвлөрч, бүх хүмүүсээс идэвхтэй оролцоо шаардаж байгаа бөгөөд замын хөдөлгөөний аюулгүй байдал, жолоодлого, гэрээлэгчийн аюулгүй байдал, аюулгүй байдлын манлайлал гэсэн гурван том эрсдэлийг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Эдгээр гурван хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлснээр бид аюулгүй байдлын үзүүлэлтүүдээ мэдэгдэхүйц сайжруулж ажиллаж байна.

Дэлхийн аюулгүй байдлын өдөр

Бид 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Дэлхийн Аюулгүй байдлын өдөрлөг зохион байгуулж, ‘Аюулгүй ажиллаад аз жаргалтай харьцаа’ санаачилгыг бүх түвшний манлайлалаар хэрэгжүүлж, дотоод сувгуудаар аюулгүй байдлыг хангах уриалга, тэмцээнийг зохион байгуулсан.

Гэрээлэгчийн аюулгүй байдал

Бид дэлхийн стандартаар дамжуулан гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчдийн аюулгүй байдлыг хангах үүднээс Гүйцэтгэгчийн аюулгүй байдлын шинэ стандартыг нэвтрүүлсэн. Энэ нь өндөр эрсдэлтэй үйл ажиллагаанд төвлөрч, гэрээлэгчдийн мэргэшлийн болон менежментийн үйл явцыг оновчтой болгох өндөр ач холбогдолтой үйл ажиллагаа болсон юм.



Хөдөлгөөний аюулгүй байдал

Монгол улсад жил тутам 20 мянга орчим зам, тээврийн осол бүртгэгддэг ба уг ослоос шалтгаалан 2020 онд 430 хүн амь нас алдсан байна. (Эх сурвалж: ТЦА-ны эмхэтгэл) Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс тээврийн хэрэгсэл болон хөдөлгөөний аюулгүй байдлын үзлэг, шалгалтыг байнга хийн аюулгүй байдлыг хангахад анхаарч ажиллаж байна.

“Мод бид хоёр” төсөл

Бидний зорилт:

АПУ ХК нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор үйлдвэрлэлийн болон ажиллагсдын түвшинд үе шаттай хөтөлбөр хэрэгжүүлж бодитой өөрчлөлт бий болгож байна.



ТХЗ-д оруулж буй хувь нэмэр:




АПУ компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг “Ногоон соёлыг түгээе” уриатайгаар ‘Мод бид 2’ төслийг амжилттай хэрэгжүүллээ. Уг төсөл нь ажиллагсдынхаа хашаанд мод, зүлэг тарих улмаар ногоон гудамж, хотыг бий болгоход нөлөөлөх алсын зорилготой төсөл юм.

Уг санаачлагыг ажиллагсад таатай хүлээн авч гэр бүлийнхээ гишүүн мэт хайрлан ургуулахаа илэрхийлсэн бол ногоон байгууламжийг бүтээхэд гар бие оролцон ажилласан, төслийг гүйцэтгэсэн компани хүнд хэцүү цаг үед жижиг дунд бизнесийг дэмжин хамтран ажилласанд талархаж буйгаа илэрхийлж байлаа.



Хог хаягдлын менежмент
АПУ ХК нь хог хаягдлын менежментийг үйлдвэрлэлээс гарч буй бүх төрлийн хатуу хог хаягдлын хүрээнд хэрэгжүүлдэг ба хог хаягдлын хэмжээг бууруулах, ландфиллд хаягдах хаягдлыг багасгах, дахивар хог хаягдлаа эргүүлэн ашиглах, дахин боловсруулахад чиглэн ажиллаж байна.



“Зүгээр битгий хая” аяны хүрээнд Өнгө Нэм ТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулж хаягдал гялгар уут дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлж нүхэн жорлонгийн доторлогоо хийж байна. Мөн түүнчлэн ЗҮБИ хүүхдийн тоглоомын талбай байгуулахад өөрсдийн хувь нэмрээ орууллаа. Лантуун ДОХИО ТББ, Plastic center ХХК -иудын хамтаар гялгар уут цуглуулж, уг орлогоор хүүхдийн тоглоомын талбай хийж БЗД-ийн 12-р хороонд хүлээлгэн өглөө.



Шингэн хаягдлын хувьд үйлдвэрээс органик түүхий эд болох улаан буудай, арвайн соёолж, хөрөнгийн үлдэгдэл, шар айраг шүүлтүүрийн материал кизелгүр зэрэг гардаг ба дахин ашиглалтыг онцгой анхаарч ажиллаж байна. Улаан буудай, арвайн соёолж, хөрөнгийн үлдэгдлийг бид малчид, фермерүүдэд, хаягдал хөрөнгө, шаарыг тэжээлийн үйлдвэрт тус тус тогтмол нийлүүлж байна.



Байгалийн нөөцийн хэмнэлт ба дахин ашиглалтын менежмент

Бидний зорилт:

Бид үйлдвэрлэл, үйл ажиллагаандаа алхам тутамдаа байгалийн нөөцийн хэмнэлт бий болгож дахин ашиглалтаа жил тутам ахиулан ажиллаж байна.



Цахилгаан, дулаан, уур, усны хэрэглээ
Байгалийн нөөцийн хэмнэлтийн зорилгын хүрээнд дулаан, цахилгаан эрчим хүч, усны хэрэглээг зорилтот түвшнээс давуулан бууруулж өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулааны хэрэглээг **17.3%**, цахилгааны хэрэглээг **8.4%**, усны хэрэглээг **22.6%** -иар тус тус бууруулсан байна.

Эрчим хүчний зарцуулалтыг бууруулах, дулааны алдагдлыг багасгах чиглэлээр тоног төхөөрөмж, техник, технологид томоохон хөрөнгө оруулалтыг хийсний дүнд 180.0 мян.кВт/цаг цахилгаан эрчим хүч, 3.0 мян. Гкал уурыг хэмнэж, нийт 1700 гаруй гэрлийг эрчим хүчний хэмнэлттэй LED технологид шилжүүлснээр гэрэлтүүлэгт зарцуулах эрчим хүчийг 54%-иар бууруулсан байна.

Ус ашиглалт
Жил бүр усны хэрэглээг багасгах, хянах үүднээс “Ус ашиглалтын зардлын норм”-ыг шинэчлэн баталдаг. 2016 онд баталсан “Ус ашиглалтын зардлын норм”-ыг, БОНХАЖ сайдын 2015 оны А/301 тоот нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормтой харьцуулахад 1000 литр бүтээгдэхүүн тутамд 2.1-3.5 дахин бага ус зарцуулж байна.

НҮҮРСХҮЧЛИЙН ХИЙ
Шар айрагний исгэлтээс ялгарч байгаа нүүрсхүчлийн хийг агаарт буюу байгаль орчинд хаялгүй боловсруулж нийт 1.980.000 кг нүүрсхүчлийн хийг үйлдвэрлэлд дахин ашигласан.

Саарал ус
Хаягдал усыг дахин ашиглах эх үүсвэр нь үйлдвэрийн тоног төхөөрөмжөөс хаягдаж байгаа ус тооцогдох ба үүнийг дахин ашиглаж Улаанбаатар хотын ногоон байгууламжийн усалгаа, угаалга, ариутгал хийхэд ашиглаж байна. Мөн үүнээс гадна үйлдвэр цехийн анхан шатны угаалга цэвэрлэгээ, үйлдвэрийн ариун цэвэрийн өрөөний суултуур зэрэгт ашиглаж байна. Усны шүүлтийн систем болон савлах үйлдвэрийн зайлсан усыг эргүүлэн ашиглах замаар нийт 13.589 м3 саарал усыг ашигласан байна.


Эко оффис
АПУ ХК нь “Ойм” ногоон урлантай хамтран компанийн оффист ногоон ургамлын тохижилт хийж ногоон соёлыг түгээхэд хувь нэмрээ орууллаа.



“Шилээ дахин амьдруулъя” төсөл

Бидний зорилт:

АПУ ХК нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хог хаягдлыг дахин ашиглах хүчин чармайлтаа жил тутам эрчимжүүлэн ажиллаж байна.



“АПУ ХК “Шилээ дахин амьдруулъя” санаачилга дэвшүүлж шилний хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэв.”



2021 онд бид нийт 12.7 сая.ш шил зах зээлээс татан авч эдийн засгийн эргэлтэд оруулсан бөгөөд бид байгальд ээлтэй амьдралын хэв маягийг сурталчилж, шилний хог хаягдлыг бууруулах #Шилээ дахин амьдруулъя аяныг амжилттай зохион байгууллаа. Энэ хүрээнд бид харилцагч байгууллагууд, хүнсний дэлгүүрүүд тэргүүтэй олон талт хамтын ажиллагааг эрхэмлэн хэрэглэгчээс өндөр үнээр буцаан худалдан авах замаар нийгэм, эдийн засагт хувь нэмэр оруулж ажиллалаа.

Түүнчлэн туршилтын байдлаар СӨХ-ны хамтын ажиллагааг идэвхжүүлж “ХОГГҮЙ МОНГОЛ” ТББ хамтран хогоо ангилан хаях сургалтаар хангаж, хог ангилах цэгүүдийг байршуулж жишиг болгон байршуулсан юм.



НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)-өөс Нүүрстөрөгчийн ялгаруулалт, байгальд өгч буй дарамт нь Монгол Улсыг Хүний хөгжлийн индексээс 10 байр хойш татаж байгааг мэдээллээд байна.

Дэлхий даяар COVID-19 цар тахалтай нүүр тулгарч аливаа бэрхшээл, сорилтуудыг хамтын хүчээр даван гарахаас өөр сонголтгүй болж байна. Цар тахлын дараа хүн төрөлхтний өмнө хамгийн чухлаар эрэмбэлэгдэн шийдэл хүлээж байгаа асуудал бол гарцаагүй байгаль экологийн тэнцвэрт байдал, уур амьсгалын өөрчлөлт болоод байна. Тиймээс Монгол улсын хувийн сектор манлайлан оролцож асуудлыг алхам алхмаар шийдэж ажиллах нь үр хойч ирээдүйн өмнө хүлээж буй компанийн нийгмийн хариуцлага юм.

АПУ компани уг асуудалд шийдэл олох хүчин чармайлтаа эрчимжүүлж хэрэглэгчдийн дунд хог хаягдлыг багасгах, улмаар дахин хэрэглээний соёлыг бий болгох замаар харилцагч, дэлгүүрүүдтэй хамтран бүтээгдэхүүний шилээ эргүүлэн татаж байгальд бий болж буй шилний эмх замбараагүй хаягдлыг бууруулахыг зорьж байна. Энэ санаачилгыг компанийн дотоод ажилтнууд ч мөн дэмжин хог хаягдлаа ялган ангилж, эргүүлэн тушаах кампанит ажлыг зохион байгууллаа.

Аливаа шилийг ангилан ялгаж, байгальд шууд хаяхгүйгээр дахин ашигласнаар түүхий эд, орц найрлагад орох байгалийн нөөц баялгийг хэмнэх, улмаар шил шинээр үйлдвэрлэхээс гарах хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ингэснээр уур амьсгалын өөрчлөлтийн хурдыг сааруулах зэрэг олон талын байгаль экологийн давуу талыг бий болгож байна.



“Шилээ дахин амьдруулъя” төсөл



Эдгээр давуу талуудаас онцгойлон дурдвал дахин ашиглаж буй шингэн хүнсний шил нь дунджаар 21 дахин байгаль орчинд ээлтэй байдаг. Мөн нэг тонн шил тутамд нэг тонн гаруй байгалийн баялгийг хэмнэдэг. 6 тонн шил дахин ашигласнаар 1 тонн нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулсантай тэнцэхүйц байдаг байна. (Тайлбар: Нүүрсхүчлийн хий нь хүлэмжийн хийн нэг төрөл ба уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарлыг бий болгож буй гол хүчин зүйлсийг нэг юм) (Эх сурвалж:Glass Recycling Institute)

Нөгөө талаас шил нь 100% дахин боловсруулах боломжтой бөгөөд чанар, цэвэршилт алдагдахгүй, ариутгалын өндөр стандартаар дахин ашиглаж болдог нь эдийн засгийн өгөөжийг тодорхойлж байна. Энэхүү төсөлд хэрэглэгч төдийгүй харилцагч дэлгүүр, бөөний болон жижиглэнгийн төв, тээврийн агентлагууд гээд олон талын төлөөлөл хамрагдах ба хэрэглэсэн шилийг дахин ашиглах нийлүүлэлтийн сүлжээ нь оролцогч тал бүрт нэмүү өртгийг бий болгож өгөөж хүртэх, ашиг олох боломжийг бүрдүүлж байгаа нь хамтын үнэ цэнийг бий болгож компанийн тогтвортой хөгжлийн бодлогын суурь болж байгаа юм. Дэлхийд дунджаар 1000 тонн шилийг дахин ангилах үйл явц тутамд 8 ажлын байр шинээр бий болдог байна. Мөн шилний импортыг бууруулж дотоод нөөц боломжоо дахин ашигласнаар валютын гадагш чиглэх урсгалыг бууруулж ханшид ч эергээр нөлөөлөх дам нөлөөтэй юм.

АПУ ХК нь шингэн хүнсний салбарын тэргүүлэгч компанийн хувьд үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн сүлжээндээ өөрсдийн бэлтгэн нийлүүлэгч, харилцагчидтай байгаль орчны чиглэлээр илүү хариуцлагатай, хамтын бодлого баримтлан ажиллаж байна.

Бид үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас гарч болох хог хаягдлыг бага түвшинд байлгах, бууруулах, хэрэглэгчдэд очиж буй бүтээгдэхүүний сав баглаа боодлын хаягдлыг дахин ашиглах боломжтой байлгах нөхцлийг бүрдүүлэхийг зорьдог. АПУ компани нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Байгаль орчны удирдлагын тогтолцоо ISO 14001:2004 стандартыг 2011 онд нэвтрүүлж улмаар 2017 онд ISO 14001:2015 шинэчлэгдсэн стандартын дагуу дэлхийд нэр хүнд бүхий SGS группын итгэмжлэлд хамрагдан баталгаажуулсан юм.



Хаягдал шил боловсруулахад бидний хувь нэмэр

Шинэ шил ХХК-тай 2021 онд хамтран ажиллаж нийт 185,000 кг шил буюу 618,000 ширхэг хаягдлыг шилийг цуглуулан хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулахад хувь нэмэр орлуулалаа.



ТХЗ-д оруулж буй хувь нэмэр:



Экологийн Цагдаагийн албатай хамтарсан “Байгаль Эн Тэргүүнд” төсөл

Бидний зорилт:

АПУ ХК нь “Тогтвортой хөгжлийн бодлого”-ын хүрээнд НҮБ-аас баталсан Тогтвортой хөгжлийн 15-р зорилго болох Хуурай газрын эко системийг хамгаалах, тэр дундаа биологийн олон янз байдлыг хангахын тулд ховордсон ан амьтныг хамгаалахаар зорьж байна.



АПУ ХК нь “Тогтвортой хөгжлийн бодлого”-ын хүрээнд НҮБ-аас баталсан Тогтвортой хөгжлийн 15-р зорилго болох Хуурай газрын эко системийг хамгаалах, тэр дундаа биологийн олон янз байдлыг хангахын тулд ховордсон ан амьтныг хамгаалах чиглэлээр “Байгаль эн тэргүүнд” төслийг Экологийн Цагдаагийн албатай хамтран амжилттай хэрэгжүүлэв.

“Байгаль эн тэргүүнд” төслийн хүрээнд загас агнуурын зохистой дадал, хэвшил бий болгох, үржлийн үед агнахгүй байх ач холбогдлыг олон нийтэд ойлгуулах, гол, мөрний экосистемийн тэнцвэртэй байдлыг хангахын тулд загасаа хайрлан хамгаалах, өсгөн үржүүлэх ойлголт, мэдээллийг сайжруулах зорилгоор “Байгаль орчин, аялал зуучлалын яам, Шинжлэх

ухааны академийн Гео-Экологийн хүрээлэн, Хөдөө Аж Ахуйн Их сургууль”-тай хамтран мэдээ, мэдээлэл түгээх, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, судалгаа мэдээллийг сайжруулах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Мөн уг төслийн хүрээнд “Зэрлэг амьтдаа хайрлая” аян зохион байгуулж хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах болон бүх нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэхийг зорьлоо.



Монгол улсын “Амьтны тухай хууль”-ийн 9, 10, 11, 12 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор зохион байгуулсан “Зэрлэг амьтдаа хайрлая” болон “Үржлийн үед барихгүй” арга хэмжээнүүд нь иргэдийн байгаль орчинтой зөв харьцаж, хамгаалах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн, буруу дадал хандлагыг сайжруулж эергээр нөлөөлсөн, зөв үйлдэлд уриалж сэдэлжүүлсэн ажил болсон гэж Экологийн Цагдаагийн албанаас онцолсон юм.

ТХЗ-д оруулж буй хувь нэмэр:



Хуурай газрын экосистемийг хамгаалах

Нийгмийн эерэг өөрчлөлтөд манлайлагч оюутан залуусыг дэмжих “Маргаашийн Манлайлагчид” төсөл

Бидний зорилт:

Нийгмийн эерэг өөрчлөлтөд манлайлагч оюутан залуусын боловсролд хөрөнгө оруулж, сурч, хөгжих, нийгэмдээ ээлтэй үйлс хийх боломжоор хангах



АПУ ХК нь 2021 онд “Хүний хөгжлийн АПУ ХК-ийн нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр нь тогтвортой бодлого”-д онцгойлон анхаарч, мэргэжил болон курс харгалзахгүй өргөн цар нийгэмд эерэг өөрчлөлтийг авчрах хүрээнд болж байгаагаараа онцлог бөгөөд манлайлагчдыг нээн илрүүлэх, тэднийг сурч нийгэм, олон нийтийн ажилд идэвхтэй боловсроход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор оролцдог, сургуульдаа тогтвортой суралцах 100 оюутны тэтгэлэгт хөтөлбөр зохион зорилготой байх гэсэн маш энгийн шалгуурыг байгууллаа.



Тэтгэлэгт хөтөлбөрт шалгарсан оюутан бүтэн 10 сарын турш амьжиргааны зардал бүхий тэтгэлэг авахаас гадна уг тэтгэлэгт хөтөлбөрийн хамтрагч байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах дадлага ажил хийх, холбогдох сургалт, хөтөлбөрүүдэд хамрагдах ба цаашлаад АПУ ХК-нд ажиллах боломжоор хангагдах гэхчилэн олон ач холбогдолтой юм. “Тогтвортой Хөгжил”-ийн үндсэн суурь зарчимд (Зорилго 4. Хүртээмжтэй, тэгш чанартай боловсролоор хангах, хүн бүрийн насан туршдаа суралцах боломжийг дэмжин хөхүүлэх) түлхэц өгөх зорилгоор хэрэгжүүлж буй энэхүү хөтөлбөрт 1500 гаруй оюутан материал ирүүлсэн бөгөөд 100 оюутныг шалгаруулж хамтран ажиллаж байна.



ТХЗ-д оруулж буй хувь нэмэр:



Тэгш, хүртээмжтэй боловсролыг дэмжих

Хүн, байгаль, хүрээлэн буй орчиндоо ээлтэй соёлыг түгээх “Соёлоор Гоёно” төсөл

Бидний зорилт:


АПУ ХК нь нийгмийн зэрэг өөрчлөлтийг соёлын нөлөөллөөр бий болгох замаар хариуцлагатай хэрэглээг бүх талаар дэмжин сурталчлахыг зорьж байна.



АПУ ХК-ийн нийгэмд чиглэсэн “Соёлоор Гоёно” төсөл 13 дахь удаагийн соёл, урлаг, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын “Мөнгөн Мод 2021” наадамд “Шилдэг зар сурталчилгаа” төрөлд шалгарсан анхны бүтээл боллоо. Хамтын нөлөөлөл, манлайлын аргачлалаар олон нийтээс фокус группийн ярилцлага, биет асуулга, хэлэлцүүлэг хэлбэрээр судалгаа авч хэрэгжүүлсэн уг төсөл нийт 2.5 сая гаруй хүнд хүрээд байна. Мөн контент үйлдвэрлэл, урлаг, хувцас загвар, сэтгүүл зүй, ТББ тэргүүтэй салбарын



төлөөлөл болсон нийт 150 гаруй хүн төслийн дуу хоолой болон хамрагджээ. Нийт 50 гаруй төрлийн контентыг олон нийтэд хүргэсэн ба контент бүрийн чиглэлийг судалгаанд суурилж нийгэм, олон нийтийн өөрсдийн бүтээхийг хүсдэг соёлын дадал хэвшилд зориулан бүтээсэн юм. АПУ ХК-ийн энэхүү санаачилга үнэт зүйл, итгэл үнэмшил нэгдсэн урлаг, соёл, хувцас загвар, бизнес, иргэний нийгмийн байгууллагууд нийт харилцагч, хэрэглэгч тэргүүтэй олон талын оролцоотойгоор амжилттай хэрэгжиж байна.



ТХЗ-д оруулж буй хувь нэмэр:



Бага болон алкогольгүй бүтээгдэхүүний инновацыг түүчээлэх

Бидний зорилт:

АПУ ХК нь нийгмийн зэрэг өөрчлөлтийг соёлын нөлөөллөөр бий болгох замаар хариуцлагатай хэрэглээг бүх талаар дэмжин сурталчлахыг зорьж байна.



Бага болон алкогольгүй бүтээгдэхүүний инновацыг түүчээлэх

Согтууруулах ундаа уухыг хүсдэггүй болон тухайн тохиолдолд хэрэглэх боломжгүй үед зорилтот хэрэглэгчдэд тохирсон бүтээгдэхүүнээр хангах тал дээр анхаарч ажиллаж байна. Бидний зорилго бол бага болон огт алкогольгүй ангиллын талаарх хэрэглэгчдийн эерэг ойлголтыг бий болгох маркетингийн кампанит ажлуудаар дэмжиж, алкогольны агууламжгүй ундааны сонголтыг бий болгох явдал юм. Ингэснээр согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, түүнээс улбаатай олон эрсдлүүдээс сэргийлэх боломжтой болох ба уг зорилгын хүрээнд бид Heineken 0.0 брэндийг Монголд танилцууллаа. Согтууруулах ундааны 0.0% ангилал 2020 онд дэлхийн хэмжээнд 4.7% -иар өссөн байна. (Эх сурвалж: Heineken)

Solar power энергийн ундаа

Бид энергийн ундаа, алкогольгүй ундааны ангилалд Solar Power брэндийг Монголд нийлүүлэв. Solar power нь эрч хүчээр хангахын тулд зөвхөн байгалийн орц найрлагыг ашигладаг бөгөөд бусад энэ төрлийн бүтээгдэхүүнүүдээс бага хэмжээний сахар агуулдаг гэдгээрээ онцлогтой.



Оргилуун хийжүүлсэн ус

Зөв зохистой хэрэглээг бий болгох, алкогольгүй шингэн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх замаар дотоодын зах зээлд шинэ бүтээгдэхүүний инноваци, хөгжүүлэлтэд онцгой анхаарч байна.

ТХЗ-д оруулж буй хувь нэмэр:



05



САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

- Дэлгэрэнгүй орлогын тайлан
- Санхүү байдлын тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан
- Өмчийн өөрчлөлтийн тайлан
- Тайлагналын зарчим
- Тайлбар толь

ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

		Аудитлагдсан НСТ 2020	Аудитлагдсан НСТ 2021
Борлуулалтын орлого (цэвэр)	сая.төг	492,337.4	678,164.1
Борлуулалтын өртөг	сая.төг	(263,409.6)	(343,229.9)
Нийт ашиг (алдагдал)	сая.төг	228,927.8	334,934.3
Борлуулалт, удирдлагын зардал	сая.төг	(112,671.1)	(138,283.4)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт	сая.төг	(540.9)	(302.0)
Бусад орлого	сая.төг	2,909.7	3,760.6
Бусад зардал	сая.төг	(2,785.0)	(2,216.8)
Үйл ажиллагааны ашиг	сая.төг	115,840.5	197,892.7
Санхүүгийн орлого	сая.төг	850.4	520.1
Санхүүгийн зардал	сая.төг	(2,248.1)	(3,653.3)
Татварын өмнөх ашиг	сая.төг	114,442.8	194,759.4
Орлогын албан татварын зардал	сая.төг	(25,699.9)	(41,073.7)
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	88,742.9	153,685.7
Бусад дэлгэрэнгүй орлого			
Ашиг, алдагдал руу дахин ангилагдахгүй зүйлс:			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	сая.төг	-	-
Ажилчдын тэтгэмжийн дахин хэмжилтийн алдагдал	сая.төг	-	(274.8)
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	сая.төг	(29.5)	(22.2)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	сая.төг	88,713.4	153,388.7
Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ноогдох	сая.төг	89,578.5	159,718.5
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ноогдох	сая.төг	(835.6)	(6,032.8)
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	88,742.9	153,685.7
Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ноогдох	сая.төг	89,549.0	159,421.5
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ноогдох	сая.төг	(835.6)	(6,032.8)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлогын нийт дүн	сая.төг	88,713.4	153,388.7
Нэгж хувьцаанд ноогдох ашиг			
Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг /алдагдал/	сая.төг	84.3	150.3

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

		Аудитлагдсан НСТ 2020	Аудитлагдсан НСТ 2021
Хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	сая.төг	262,519.8	283,564.6
Биет бус хөрөнгө ба гүүдвил	сая.төг	87,305.9	80,977.0
Хойшлогдсон татварын хөрөнгө	сая.төг	1,252.3	1,033.9
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	351,078.1	365,575.4
Бараа материал	сая.төг	83,348.4	87,714.1
Урьдчилгаа, урьдчилж төлсөн зардал	сая.төг	17,664.4	53,774.2
Орлогын албан татварын авлага	сая.төг	-	148.3
Дансны болон бусад авлага	сая.төг	39,013.1	32,722.6
Бусад санхүүгийн хөрөнгө оруулалт	сая.төг	500.0	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	сая.төг	64,059.2	77,277.7
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	204,585.1	251,636.8
Нийт хөрөнгө	сая.төг	555,663.2	617,212.2
Эздийн өмч			
Хувьцаат капитал	сая.төг	106.3	106.3
Нэмж төлөгдсөн капитал	сая.төг	338,094.9	338,094.9
Нэгдлийн нөөц	сая.төг	(112,795.8)	(112,795.8)
Дахин үнэлгээний нөөц	сая.төг	100,177.6	99,774.3
Гадаад валютын хөрвүүлгийн нөөц	сая.төг	(21.3)	(43.4)
Хуримтлагдсан ашиг	сая.төг	129,937.4	179,766.5
Хяналтын эрхгүй хувь оролцоо	сая.төг	6,116.6	83.8
Нийт эздийн өмч	сая.төг	461,615.7	504,986.5
Өр төлбөр			
Хойшлогдсон татварын өглөг	сая.төг	18,088.6	15,978.2
Урт хугацаат түрээсийн өглөг	сая.төг	7,764.2	13,134.4
Ажилтны тэтгэмж	сая.төг	656.5	816.8
Урт хугацааны зээл	сая.төг	2,000.0	21,115.4
Урт хугацаат өр төлбөр	сая.төг	28,509.3	51,044.8
Богино хугацаат түрээсийн өглөг	сая.төг	2,318.6	5,266.4
Орлогын албан татварын өглөг	сая.төг	2,698.0	8,145.8
Дансны өглөг	сая.төг	11,312.4	21,965.0
Бусад өглөг	сая.төг	49,209.2	25,803.7
Богино хугацаат өр төлбөр	сая.төг	65,538.2	61,180.9
Нийт өр төлбөр	сая.төг	94,047.5	112,225.7
Нийт өр төлбөр ба эздийн өмч	сая.төг	555,663.2	617,212.2

		Аудитлагдсан НСТ 2020	Аудитлагдсан НСТ 2021
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Тайлант жилийн ашиг	сая.төг	88,742.9	153,685.7
Тохируулга:	сая.төг		
Орлогын албан татварын зардал	сая.төг	25,699.9	41,073.7
Зээлийн хүүгийн зардал	сая.төг	20.5	802.0
Түрээсийн хүүгийн зардал	сая.төг	2,227.6	2,092.3
Нөөцийн дискаунтын чөлөөлөлт	сая.төг		44.0
Хүүгийн орлого	сая.төг	(724.3)	(520.1)
Валютын ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй гарз/(олз), цэвэр	сая.төг	(493.7)	(154.0)
Элэгдлийн зардал	сая.төг	32,266.9	36,040.3
Хорогдуулгын зардал	сая.төг	7,126.0	7,381.2
Дансны болон бусад авлагын үнэ цэнийн бууралт, (цэвэр)	сая.төг	502.9	262.4
Банкны үлдэгдэл дэх үнэ цэнийн бууралт	сая.төг	38.0	39.6
Бараа материалын үнэ цэнийн бууралт	сая.төг	819.8	179.6
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	сая.төг	(26.0)	(101.6)
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	сая.төг	513.4	442.6
Хасагдсан үндсэн хөрөнгө	сая.төг	657.0	381.1
Биет бус хөрөнгө борлуулсны гарз	сая.төг	-	-
	сая.төг	157,370.8	241,648.9
Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлт:			
Дансны авлага болон бусад авлага	сая.төг	96.6	6,027.8
Бараа материал	сая.төг	5,301.1	(4,560.5)
Урьдчилгаа	сая.төг	(8,315.9)	(16,134.3)
Дансны өглөг	сая.төг	(578.8)	10,728.3
Бусад өглөг	сая.төг	13,882.1	(15,864.2)
Ажилтны тэтгэмж	сая.төг	656.5	(158.5)
	сая.төг	168,412.4	221,687.5
Зээлийн хүүний төлбөрт төлсөн	сая.төг	(101.2)	(802.0)
Түрээсийн хүүний төлбөрт төлсөн	сая.төг	(2,227.6)	(2,092.3)
Хүлээн авсан хүүгийн орлого	сая.төг	724.3	520.1
Төлсөн орлогын албан татвар	сая.төг	(22,375.0)	(37,666.6)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	144,433.0	181,646.7

		Аудитлагдсан НСТ 2020	Аудитлагдсан НСТ 2021
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Худалдаж авсан үндсэн хөрөнгө	сая.төг	(35,288.9)	(65,083.7)
Худалдаж авсан биет бус хөрөнгө	сая.төг	(1,352.8)	(1,052.3)
Худалдаж авсан хяналтын эрхгүй хувь оролцоо	сая.төг	-	-
Борлуулсан үндсэн хөрөнгө	сая.төг	1,027.3	42.3
Бусад санхүүгийн хөрөнгө оруулалтыг олж эзэмшихэд төлсөн	сая.төг	(500.0)	-
Бусад санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсан	сая.төг	-	500.0
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(36,114.4)	(65,593.7)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Зээлийн эргэн төлөлт	сая.төг	-	-
Төлсөн ногдол ашиг	сая.төг	(101,739.6)	(118,447.2)
Түрээсийн өглөгт төлсөн	сая.төг	(2,137.7)	(3,438.0)
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	сая.төг	6,952.3	-
Урт хугацааны зээл авсан	сая.төг	2,000.0	19,115.6
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(94,925.1)	(102,769.6)
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	сая.төг	(34.2)	(8.0)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт / (бууралт)	сая.төг	13,359.4	13,275.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	сая.төг	50,034.9	64,059.2
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийн бууралт	сая.төг	(38.0)	(39.6)
Мөнгөн хөрөнгө дэхь гадаад валютын ханшийн хэлбэлзлийн нөлөөлөл	сая.төг	702.9	(17.2)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	сая.төг	64,059.2	77,277.7

ҮЗҮҮЛЭЛТ	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Нэгдлийн нөөц	Дахин үнэлгээний нөөц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн	Хяналтын эрхгүй хувь оролцоо	Нийт дүн	
2020 эхний үлдэгдэл / нэгтгэсэн/	сая. төг	106.3	338,094.9	(112,795.8)	101,458.1	8.2	154,411.1	481,282.8	-	481,282.8
Нийт дэлгэрэнгүй орлого	сая. төг	-	-	-	-	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	сая. төг	-	-	-	-	-	89,578.5	89,578.5	(835.7)	88,742.9
Бусад дэлгэрэнгүй орлого	сая. төг	-	-	-	-	(29.5)	-	(29.5)	-	(29.5)
Зарласан ногдол ашиг	сая. төг	-	-	-	-	(115,332.8)	(115,332.8)	-	(115,332.8)	-
Худалдаж авсан хяналтын эрхгүй хувьцаа	сая. төг	-	-	-	-	-	-	6,952.3	-	6,952.3
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн	сая. төг	-	-	-	(1,280.6)	-	1,280.6	-	-	-
2020 эцсийн үлдэгдэл / нэгтгэсэн/	сая. төг	106.3	338,094.9	(112,795.8)	100,177.6	(21.3)	129,937.4	455,499.1	6,116.6	461,615.7
Нийт дэлгэрэнгүй орлого	сая. төг	-	-	-	-	-	(274.8)	(274.8)	-	(274.8)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	сая. төг	-	-	-	-	-	159,718.5	159,718.5	(6,032.8)	153,685.7
Бусад дэлгэрэнгүй орлого	сая. төг	-	-	-	-	(22.1)	-	(22.1)	-	(22.1)
Зарласан ногдол ашиг	сая. төг	-	-	-	-	(110,017.8)	(110,017.8)	-	(110,017.8)	-
Худалдаж авсан хяналтын эрхгүй хувьцаа	сая. төг	-	-	-	-	-	-	-	-	-
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн	сая. төг	-	-	-	(403.2)	-	403.2	-	-	-
2021 эцсийн үлдэгдэл / нэгтгэсэн/	сая. төг	106.3	338,094.9	(112,795.8)	99,774.3	(43.4)	179,766.5	504,902.8	83.8	504,986.5

ТАЙЛАГНАЛЫН НИЙЦЭЛ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Монгол улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актын хүрээнд бэлтгэсэн. Уг тайланг Санхүүгийн тайлангийн Олон Улсын Стандарт (“СТОУС”) 10 буюу “Нэгтгэсэн санхүүгийн Тайлан” хэмээх стандартын арга аргачлалыг ашиглан бэлтгэсэн.

ҮНЭЛГЭЭНИЙ СУУРЬ

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулахдаа санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэсэн.

БҮРТГЭЛИЙН БОЛОН ТОЛИЛУУЛГЫН ВАЛЮТ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг компанийн бүртгэлийн валют болох Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр толилуулсан бөгөөд энэ нь компанийн үйл ажиллагаа явуулж буй анхдагч эдийн засгийн орчны үндсэн валют болно.

ТААМАГЛАЛ, ТООЦООЛОЛ БОЛОН ҮНЭЛЭМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС болон НББОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, мөн хөрөнгө, өр төлбөр, орлого зардлын зүйлсийн дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр тооцоолоос зөрүүтэй байж болно. Удирдлага эдгээр тооцоолол болон түүнд хэрэглэсэн таамаглалыг байнга хянаж байдаг.

ГАДААД ВАЛЮТААРХ АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн мөнгөн зүйлсийг балансын өдрийн хаалтын ханшаар төгрөг рүү хөрвүүлэн илэрхийлдэг.

Бодит үнэ цэнээр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийн зүйлсийг тухайн бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлдэг. Түүхэн өртгөөр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар тайлагнадаг.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ. Компани нь зээл болон авлагыг анх үүссэн тухай бүр нь хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн хөрөнгүүдийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг. АВЛАГА. Уг хөрөнгийг бодит үнэ цэнэ дээр тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан шууд зардлыг нэмсэн дүнгээр анх хүлээн зөвшөөрдөг.

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР. Компани нь гаргасан өрийн бичиг, өр төлбөрийг тухайн ажил гүйлгээг үүссэн өдрөөр хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн өр төлбөрийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг.

САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨРИЙГ ЦЭВЭР ДҮНГЭЭР ТУСГАХ.

Компани хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь хаах хууль эрх зүйн эрхтэй байх, мөн цэвэр дүнгээр нь төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах зорилготой үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг.

ҮНДСЭН ХӨРӨНГӨ

АНХДАГЧ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ. Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй үндсэн хөрөнгийн зүйлсийг анхны удаа өртгөөр нь хэмждэг. Өртөгт тухайн хөрөнгийг худалдан авахтай шууд холбогдон гарсан зардлууд багтдаг.

ДАРАА ҮЕИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ.

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа үндсэн хөрөнгийг түүний бодит үнэ цэнийг илтгэх дахин үнэлсэн дүнгээр хэмжих ба дахин үнэлсэн дүн нь дараа үеийн хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байдаг. Хөрөнгийн бодит үнэ цэнийг Монгол Улсын хараат бус гуравдагч этгээд тогтоодог.

ДАРАА ҮЕИЙН ЗАРДАЛ.

Дараа үеийн зардлыг зөвхөн эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай гэдэг нь тогтоогдсон үед капиталжуулан бүртгэдэг. Урсгал засварын зардлыг гарсан тухайн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрдөг.

ЭЛЭГДЭЛ.

Үндсэн хөрөнгийн зүйлсийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн ашиглалтын жилээр тооцон шулуун шугамын аргаар элэгдүүлж, орлогын тайланд бүртгэдэг. Үндсэн хөрөнгийг түүнийг байршуулж, ашиглахад бэлэн болсон үеэс нь, дотооддоо барьж байгуулсан хөрөнгийн хувьд тэдгээрийг дуусгавар болгож, үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон үеэс нь эхлэн элэгдэл байгуулдаг.

БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Компани биет бус хөрөнгө худалдан авсан бөгөөд түүний ашиглалтын жилийг тодорхойлох боломжтой бол түүний өртгөөс хуримтлагдсан хорогдуулга болон үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ

Биологийн хөрөнгийг борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнээр нь хэмжих бөгөөд үүнтэй холбоотой үүсэх олз ба гарзыг тухайн тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

ЗЭЭЛИЙН ӨРТӨГ

Компани бэлтгэл шаардагдах хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай зээлийн өртгийг тухайн хөрөнгийн өртгийн хэсэг болгон капиталжуулдаг. Бусад зээлийн өртгийг гарсан тайлант үед нь зардлаар хүлээн зөвшөөрдөг.

БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар үнэлдэг. Бараа материалын өртгийг дундаж өртгийн аргаар тодорхойлох бөгөөд бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбогдож гарсан бүх зардлууд ордог. Үйлдвэрийн бараа материал, дуусаагүй үйлдвэрлэлийн хувьд хэвийн хүчин чадлаар ажиллах үеийн үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын зохих хэсгийг өртөгт хуваарилдаг.

ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ**ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ.**

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдээгүй санхүүгийн хөрөнгийн хувьд тэдгээрт үнэ цэнийн бууралт үүссэн гэдэг бодит нотолгоо байгаа эсэхийг тайлант хугацааны эцэс бүрт үнэлж тодорхойлдог.

ХОРОГДУУЛСАН ӨРТГӨӨР ИЛЭРХИЙЛСЭН САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ.

Компани эдгээр хөрөнгүүдийг тусад нь мөн хамтад нь үнэ цэнийн бууралтын нотолгоо байгаа эсэхийг үздэг. Бүх мэдэгдэхүйц хэмжээний хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тусад нь үнэлнэ.

САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ.

Тайлант үеийн эцэст бараа материал, хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад санхүүгийн бус хөрөнгийн дансны үнэнд үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрсэн бол тухайн хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно.

АЖИЛЧДЫН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, УРАМШУУЛАЛ АЖИЛЧДЫН БОГИНО ХУГАЦААТ ТЭТГЭМЖ. Холбогдох үйлчилгээ үзүүлсэн үед ажилчдын богино хугацаат тэтгэмжийг зардлаар бүртгэдэг. Компани нь ажилтны үзүүлсэн үйлчилгээний дагуу компанид үүрэг хариуцлага үүссэнээс найдвартайгаар тооцоолж болох компанийн төлөх ёстой дүнгээр өр төлбөрөө хүлээн зөвшөөрдөг.

ТОГТООСОН ШИМТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ. Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж нь Монгол Улсын Нийгмийн Даатгалын Санд төвлөрүүлэх хуулиар тогтоосон нийгмийн даатгалын шимтгэлээс бүрдэнэ. Тодорхой шимтгэлийн дүн бүхий тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөрт төвлөрүүлэх шимтгэлийг түүнийг төлөх үүрэг хүлээсэн тайлант үеийн зардлаар бүртгэдэг.

НӨӨЦ БА БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Компани өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, уг үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөц шаардлагатай гэдэг нь тодорхой болсон ба үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой болсон үед санхүүгийн байдлын тайланд нөөцийг хүлээн зөвшөөрдөг.

ХУВЬЦААТ КАПИТАЛ**ЭНГИЙН ХУВЬЦАА.**

Энгийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилж, бүртгэдэг. Энгийн хувьцаа нэмж гаргахтай холбоотой нэмэгдэл зардлыг татварын нөлөөллийн дараах цэвэр дүнгээр нь эздийн өмчийн бууралтаар хүлээн зөвшөөрдөг.

ХАЛААСНЫ ХУВЬЦАА.

Хувьцаат капиталыг буцаан худалдан авсан үед аливаа татварын нөлөөллийн дараах худалдан авахтай холбоотой гарсан шууд зардлыг багтаасан дүнгээр эздийн өмчийн бууралт гэж бүртгэдэг.

Буцаан худалдан авсан хувьцааг халаасны хувьцаа гэж нэрлэх бөгөөд өмчийн өөрчлөлтийн тайланд халаасны хувьцаа гэж тайлагнадаг. Халаасны хувьцааг дахин борлуулсан эсвэл дахин эргэлтэнд гаргасан үед хүлээн авсан дүнг өмчийн өсөлтөөр бүртгэдэг бөгөөд тухайн ажил гүйлгээтэй холбогдон гарсан өсөлт, бууралтыг нэмж төлөгдсөн капитал гэж толилуулдаг.

ХУВЬЦААТ КАПИТАЛ, НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ БА БУСАД НӨӨЦҮҮД

Эвэргрийн Инвестментс ХХК-тай нэгдсэн талаар Холбогдох эрх бүхий байгууллагуудаас зохих зөвшөөрлүүдийг шат дараатай авсны үндсэн дээр нэгдлийн ажил гүйлгээ 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөр дуусгавар болсон. Эцсийн үе шатанд Эвэргрийн Инвестментс ХХК компанид нэгдсэн бөгөөд компани нь нэгдсэн компаниуд, тэдгээрийн охин компаниудын толгой компани болсон. Нэгдлийн үр дүнд дараах өмчийн дахин зохион байгуулалтыг хийсэн:

2017 оны 8 дугаар сарын 18-ны өдөр компанийн хувьцаа эзэмшигчид нийт 338,127,000 мянган төгрөгөөр капиталыг нэмэгдүүлэх замаар Эвэргрийн Инвестментс ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд нийт 321,305 мянган ширхэг энгийн хувьцааг шинээр гаргасан. Уг капитал нь 32,130 мянган төгрөгийн хувьцаат капитал болон 338,094,870 мянган төгрөгийн нэмж төлөгдсөн капиталаас бүрдсэн. Нэгдлийн нөөц

Бизнесийн нэгдлийн хүрээнд компанийн шилжүүлсэн төлбөр нь Эвэргрийн Инвестментс ХХК-тай хийсэн нэгдэлд зориулж шинээр гаргасан хувьцаа болно. Өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо бодит үнэ цэнийн 1 дүгээр шатлалын хэмжүүр болох компанийн хувьцааны зах зээлийн үнэ цэнийг ашигласан. Нэмж гаргасан

хувьцааны бодит үнэ цэнэ болон хуулийн дагуу бүртгэгдсэн үнэ цэнийн зөрүү болох 112,795,804 мянган төгрөгийг нэгдлийн нөөц гэж бүртгэсэн.

ОРЛОГО

Бараа борлуулалтын орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжиж бүртгэлд тусгадаг. Ингэхдээ компани эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлал өндөр бөгөөд орлого ба өртөг зардлыг бодитоор хэмжих боломжтой байх ёстой.

БАРАА БОРЛУУЛАЛТ.

Бараа агуулахаас ачигдан, худалдан авагчийн талбайд хүргэгдэж, худалдан авагч барааг хүлээн авч, эрсдэл болон өмчлөл нь худалдан авагчид бүрэн шилжсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрдөг. Орлогын дүнд нэмэгдсэн өртгийн албан татвар болон бусад борлуулалтын татварыг оруулдаггүй ба худалдааны хөнгөлөлт, урамшууллыг хассан цэвэр дүн байдаг.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮРЭЭСИЙН ОРЛОГО. Үйл ажиллагааны түрээсийн орлогыг түрээсийн хугацааны туршид төлөгдөх ижил хэмжээний хэсэгчилсэн төлөлтөөр орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Хүлээн авсан түрээсийн хөрөнгийн урамшууллыг түрээсийн нийт зардлын дүнд тооцон түрээсийн хугацааны туршид хүлээн зөвшөөрдөг. Болзошгүй түрээсийн орлогыг тухайн орлогыг олсон тайлант хугацаанд хүлээн зөвшөөрдөг.

БУСАД ОРЛОГО.

Компанийн үндсэн үйл ажиллагаанаас гадна бий болж буй орлогыг бусад орлого гэх бөгөөд тухайн орлогын эдийн засгийн өгөөжийг компани хүртэх магадлалтай ба үүнийг найдвартай хэмжин тодорхойлох боломжтой болсон үед компани бусад орлогыг хүлээн зөвшөөрдөг.

САНХҮҮГИЙН ОРЛОГО БА САНХҮҮГИЙН ЗАРДАЛ

Санхүүгийн орлогод хөрөнгө оруулалтаас хүртэх хүүгийн орлого орно. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцож, орлогын тайланд хуримтлуулан бүртгэдэг.

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардлаас бүрддэг. Зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцож, орлогын тайланд бүртгэдэг.

ТАЙЛБАР ТОЛЬ

ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ

Орлогын албан татварын зардал нь тайлант жилийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Тайлант жилийн татвар болон хойшлогдсон татварыг эздийн өмч эсвэл бусад дэлгэрэнгүй орлогоор шууд хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг.

НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ

Компани энгийн хувьцааны хувьд нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр ашиг, алдагдлыг тайлант хугацааны туршид эргэлтэнд байсан энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоонд хуваах замаар нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог.

ХОЛБООТОЙ ТАЛУУД

Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд компанитай холбоотой гэж үзнэ:

- Компанийг хянадаг эсвэл хамтран хянадаг;
- Компанид мэдэгдэхүйц нөлөөлөлтэй;
- Компанийн эсвэл түүний толгой компанийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.

Хувь хүний гэр бүлийн ойр дотны гишүүд гэдэг нь компанитай ажил хэргийн харилцаанд орох явцад хувь хүнд нөлөөлөх эсвэл түүний нөлөөнд автаж болзошгүй гэр бүлийн гишүүд юм.

ТАЙЛАНТ ҮЕ

Аж ахуйн нэгж, байгууллагын ашиг, алдагдлыг тооцож буй хугацааг хэлнэ. Ерөнхийдөө улирал, жилийг хамруулж авч үзнэ.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Иж бүрэн санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдэнэ.

ХӨРӨНГӨ

Хөрөнгө гэдэг нь өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд бий болж, байгууллагын мэдэлд орсон бөгөөд ирээдүйд үр өгөөжөө өгөх нөөц, баялаг, хөрөнгө юм.

ББХ-БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгөтэй адил биетээр, бодитоор оршдоггүй хэдий ч эзэмшигчдэдээ давуу тал болон давуу эрхийг олгодог патент, лиценз, зохиогчийн эрх, барааны тэмдэг, нэр төр, гүүдвил гэх мэт удаан хугацаанд үнэ цэнэтэй байх актив (хөрөнгө)-ыг хэлнэ.

ҮХ-ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Байшин, барилга, машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил гэх мэт худалдан борлуулах зориулалтгүй, үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаанд урт хугацаанд ашиглагдах буюу 1 жилээс бага хугацаанд борлогдож мөнгөн хөрөнгө болохгүй хөрөнгийг хэлнэ.

ЭБХ-ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийг хэлнэ.

ЭХ-ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй явуулахад ашиглагдах нэг жил буюу түүнээс бага хугацаанд бэлэн мөнгө болж хувирах хөрөнгийг хэлнэ.

УТЗ-УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ

Ажил үйлчилгээ авахаас өмнө буюу үр дүн нь гарахаас өмнө төлсөн төлбөр

ДАНСНЫ АВЛАГА

Үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах мөнгөн дүн.

БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

3 сараас нэг жилийн хугацаатай хадгаламж, богино хугацаат хөрөнгө оруулалт хамаарна.

МӨНГӨТЭЙ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Үнэ цэнийг нь өөрчлөхөд өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөнд шууд хөрвөх нэгээс гурван сарын хугацаатай хөрөнгө оруулалт юм.

МӨНГӨН СУУРТ АРГА

Бэлнээр мөнгө хүлээж авсан үед нь орлогод, бэлнээр мөнгө төлсөн үед нь зардалд бүртгэх нягтлан бодох бүртгэлийн арга.

АККРУЭЛ СУУРТ АРГА

Мөнгө хүлээн авсан, эсхүл төлснөөс үл хамааран ажил үйлчилгээний гүйцэтгэлтэй уялдуулан орлогыг олсон, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэлнэ.

ХУВЬЦААТ КАПИТАЛ

Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө юм.

ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ

Аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансны үнэ дахин үнэлгээний үр дүнд өссөн дүнг хэлнэ.

ӨР ТӨЛБӨР

Бусдад төлөх ёстой мөнгө (хувь хүн, компани, эсхүл Засгийн газрын өр байж болно).

УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Нэг жилээс дээш хугацаанд төлөгдөх дотоодын болон гадаадын эх үүсвэр, холбоотой талаас авсан зээлийг хэлнэ.

БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

12 сарын дотор төлбөр нь төлөгдөх өр төлбөрийг хэлнэ.

НДШ-НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг санхүүжүүлэх зорилгоор ажилчид болон ажил олгогчдод ногдуулах татвар.

ОТ-ОРЛОГЫН ТАЙЛАН

Компанийн олсон орлого, гаргасан зардлыг тодорхой хугацаагаар (улирал, жил) тасалбар болгон харуулсан тайлан

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

Тайлангийн хугацаанд худалдсан бараа, бүтээгдэхүүн үйлчилгээний үйл ажиллагаанаас олсон орлогыг хэлнэ.

БОРЛУУЛАЛТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

Тайлант үед борлуулсан барааны өртгийг хэлнэ.

НИЙТ АШИГ

Байгууллагын тодорхой хугацаан дахь үйл ажиллагааны үр дүнгийн мөнгөн илэрхийлэл буюу бизнес эрхэлж, эрсдэл хүлээсний төлөө авч буй үр өгөөж, компанийн нийт орлогоос бүх мөнгөн болон хийсвэр зардлыг хасч тооцно.

ҮАЗ-ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Бизнес эрхлэхэд гарч буй зардал.

ХТӨА

Хүү татварын өмнөх ашиг

ЦЭВЭР АШИГ

Компанийн орлогоос бүх төрлийн зардал болон татварыг хасаад үлдэж буй ашгийн хэмжээ.

ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ

Орлогын албан татварын зардал нь орлогын албан татварын өмнөх ашиг нь хувиар илэрхийлсэн

ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

Засгийн газраас аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогод ногдуулж буй татвар

МГТ-МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Байгууллагын тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн өөрчлөлтийг харуулсан тайлан

ҮҮАМГ

Үндсэн Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ байгууллагын орлого олох үндсэн үйл ажиллагаанаас орж ирэх мөнгөн хөрөнгийг хэлнэ

ГХО

Гадаадын хөрөнгө оруулалт





APU COMPANY

Absolute. Pure. Unique.

АПУ ХУВЬЦААТ КОМПАНИ
Улаанбаатар хот - 17040, Чингисийн өргөн чөлөө - 14,
Утас: +976 - 7600 2220, Факс: +976 - 11 - 343063
www.apu.mn